

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДЭЖ,  
ЦАХИМЖИЛТ САЙЖИРСАН ХЭДИЙ Ч БҮТЭЦ, ХҮНИЙ НӨӨЦ БОЛОН  
ТӨСВИЙН АСУУДЛААС ШАЛТГААЛАН ХЯНАЛТ, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ  
ДУТМАГ БАЙНА.

**АУДИТЫН КОД: ӨВА-2026/14-14/ШТА-НА**



**Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал**

Утас: 7032-3253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

**Аудитын менежер П.Хорлоосүрэн**

Утас: 7032-3108 Цахим хаяг: KhorloosurenP@audit.gov.mn

**Ахлах аудитор: Ө.Ринчинмядаг**

Утас: 7032-3833 Цахим хаяг: RinchinmyadagU@audit.gov.mn

**Аудитор: Р.Энхзул**

Утас: 7032-3833 Цахим хаяг: EnkhzulR@audit.gov.mn

**Аудитор: Д.Очирбат**

Утас: 7032-3833 Цахим хаяг: OchirbatD@audit.gov.mn

**Аудитор: Б.Нямсэмжаан**

Утас: 7032-3108 Цахим хаяг: NyamsemjaanB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг [www.audit.mn](http://www.audit.mn) хаягаас авна уу.  
**Өвөрхангай аймаг 2026 он**

**АГУУЛГА**

<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>4</b>
<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>5</b>
<b>ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>5</b>
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>5</b>
<b>АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ .....</b>	<b>6</b>
<b>БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН АКТУУД ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ НИЙЦЭЖ БАЙГАА Ч СУМДЫН ТӨРИЙН САНГИЙН ТҮВШИНД ЧИГ ҮҮРГИЙН ДАВХАРДАЛ ҮҮСЭЖ БАЙГАА ТУЛ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....</b>	<b>10</b>
1.1. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актууд холбогдох хууль тогтоомжтой нийцэж байна. ....	10
1.1.2. Холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэрүүд хууль тогтоомжтой нийцэж байна. ....	10
1.2. Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн хувьд төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц бүрдсэн бол сумдын төрийн сан чиг үүргийн давхардал үүссэн бүтэц, зохион байгуулалт оновчгүй байна. ..	11
1.2.1. Сумдын төрийн сангийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт оновчгүй байна. ....	11
1.2.2. Сумдын Төсвийн ерөнхий нягтлан бодогч болон төсөв, төрийн сангийн мэргэжилтний зарим чиг үүрэг нь давхардсан, албан тушаалын тодорхойлолтод оновчтой тусгаагүй, төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй бүрэн нийцээгүй байна. ...	13
1.2.3. Төрийн сангийн цахим системийн удирдлага, зохицуулалт, мэдээллийн аюулгүй байдал, хэрэгцээ шаардлага нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байна. ....	21
<b>БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХИЙН ТУЛД ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ТОГТВОРЖУУЛАХ, ТӨРИЙН САНГИЙН БОЛОН ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН БОЛОВСОН ХҮЧНИЙГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ НЭН ЧУХАЛ БАЙНА. ....</b>	<b>27</b>
2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт төсвийн хязгаар, орлого бүрдүүлэлтээс хамааран батлагдсан төсөв, төсвийн хуваарийн дагуу олгогдохгүй, шат шатны байгууллагуудад төрийн сангийн үйл ажиллагааны журмын мөрдөлтийг сайжруулах шаардлагатай байна. ....	27
2.1.1. Төсвийн санхүүжилтийн эрх олголт нь батлагдсан төсвийн хуваарь, хууль тогтоомж, холбогдох баримт бичгийн шаардлагад нийцэж байгаа ч төсвийн орлого бүрдүүлэлт, хязгаарлалттай холбоотой хугацаандаа олгогдоогүй байна. ....	27
2.1.2. Аймаг, сумын төсөвт байгууллагуудын төрийн өмчийн барилгын тогтмол зардлын зарцуулах эрхийг эдийн засгийн ангилал болон шаардлагад нийцүүлэн олгож байна. ....	29
2.2. Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагааг сайжруулж, гүйлгээг хянаж буй төрийн сангийн мэргэжилтэн, төсвийг захиран зарцуулж буй удирдлага, нягтлан бодогчдын хариуцлагыг нэмэгдүүлж, чадавхжуулах шаардлагатай байна. ....	31
2.2.1. Аймаг, сумдын хэмжээнд бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэлтэй тулган баталгаажуулж байгаа боловч хагас жил тутам тогтмол хийдээгүй, Төрийн сангийн баталгаажуулалт хангалтгүй байна. ....	31
2.2.2. Төрийн сангийн төлбөр, тооцооны гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан эсэхэд зохих хяналт, баталгаажуулалт хийгээгүй гүйцэтгэсэн нь хяналт сул байгааг харуулж байна. ....	33
2.2.3. Аймгийн СТСХ болон ихэнх сумд бүртгэлийн дансны тодорхойгүй орлого, буцаалтыг журмын дагуу дансанд байршуулж, холбогдох баримтыг үндэслэн гүйлгээг	

---

залруулан буцаалтыг хийж байгаа бол зарим сумд 140020 ангиллаас орлого бууруулан гүйлгээ хийсэн байна.....	37
2.3. Төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж буй дотоод болон хөндлөнгийн хяналтууд нь үр нөлөөгөө өгч байгаа хэдий ч өгсөн шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилт, биелэлтийг дүгнэж, үр дүнг сайжруулах шаардлагатай байна.....	41
2.3.1. Төрийн сангийн төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус дотоод хяналтыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу тогтмол хэрэгжүүлж ажилласан боловч сумдад өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, биелэлтийн үр дүнг үнэлж дүгнээгүй байна. ....	41
2.3.2. Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг зааврын дагуу үнэлж, өдөр тутмын дотоод хяналтыг бүх шатны төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажилласан боловч түүний үр нөлөө, хэрэгжилтийг цаашид сайжруулах шаардлагатай байна. ....	43
2.3.3. Хөндлөнгийн хяналт нь зөрчлийг бууруулахад тодорхой үр дүнгээ өгч байгаа боловч сумдын түвшинд давтагдан илэрдэг зөрчлүүд арилахгүй байна.....	44
<b>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ .....</b>	<b>47</b>
<b>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ХАРИУ .....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>48</b>
<b>САНАЛ .....</b>	<b>48</b>
<b>Хавсралт 1. Түүвэрлэсэн гүйлгээ 2023-2025 он /сая.төг/ .....</b>	<b>52</b>
<b>ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ .....</b>	<b>53</b>

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БХЭ	Барьцаа хөрөнгийн эрх
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗХЭ	Захиалагчийн хяналтын эрх
ЗЭБ	Зарцуулах эрхийн баталгаа
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ННС	Нэвтрэлтийн нэгдсэн сан
НТ	Нэгдсэн төсөв
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СЭБ	Санхүүжилтийн эрхийн бүртгэл
ТСГ	Төрийн сангийн газар
ТСУЦС	Төрийн сангийн удирдлагын цахим систем
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХОС	Хөрөнгө оруулалтын санхүүжилт

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн орон тоо .....	11
Хүснэгт 2. Аймаг болон сумдын Төсөвт байгууллага, Сан, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, суманд бүртгэлтэй аж ахуй нэгжийн тоо .....	19
Хүснэгт 3. Аймаг, сумдын төрийн сан, төрийн байгууллага ашигладаг СЯ-ны систем. ....	22
Хүснэгт 4. Асуумжаар ирсэн саналууд/төрийн сангийн мэргэжилтэн/. Системээс шалтгаалсан .....	24
Хүснэгт 5. Асуумжаар ирсэн саналууд /төрийн сангийн мэргэжилтэн/. Хэрэглэгчээс шалтгаалсан .....	25
Хүснэгт 6. Асуумжаар ирсэн саналууд /нягтлан бодогч/. Системээс шалтгаалсан .....	26
Хүснэгт 7. Асуумжаар ирсэн саналууд /нягтлан бодогч/. Хэрэглэгчээс шалтгаалсан.....	26
Хүснэгт 8. 2023-2025 оны санхүүжилт. /сая.төг/ .....	28
Хүснэгт 9. Сумдын санхүүгийн дэмжлэгийг задлан харуулбал /сая.төг/ .....	28
Хүснэгт 10. Нэмэлт санхүүжилтийн эрх олголтыг 2023-2025 оны байдлаар харуулбал .....	30
Хүснэгт 11. Баталгаажуулсан бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгаа .....	31
Хүснэгт 12. Төрийн сангийн цахим системээр 2023-2025 онд хийгдсэн зарлагын гүйлгээ ..	33
Хүснэгт 13 2024-2025 оноос түүвэрлэн 4 дүгээр сарын эцсийн ажлын өдрийн гүйлгээ хийсэн цаг .....	35
Хүснэгт 14 Зардлын гүйлгээний түүвэр /сая.төг/ .....	35
Хүснэгт 15. Төрийн сангийн цахим системээр 2023-2025 онд 140020 ангилалд орсон орлого /сая.төг/ .....	37
Хүснэгт 16 Аймгийн төсвийн гүйцэтгэл 2023-2025 он .....	39
Хүснэгт 17 Дотоод хяналт 2023-2025 .....	41
Хүснэгт 18 ТАБ-ын санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн дүн /сая.төг/ .....	45
Хүснэгт 19 ТАБ-ын санхүүгийн тайлангийн аудитын зөрчил төрлөөр /мян.төг/ .....	45
Хүснэгт 20. Аймаг болон сумдын Засаг дарга нарын нэгдсэн санхүүгийн тайлангийн дүгнэлт .....	45

## ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэл 1. Сумын санхүүгийн албаны зохион байгуулалт .....	12
Дүрслэл 2. Гүйлгээний дүрслэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Сангийн яамны төлбөр тооцооны системүүд .....	8
Зураг 2. Банк хоорондын системийн шинэчлэлт .....	9
Зураг 3. Сангийн яамны системүүд .....	9
Зураг 4. Төхөөрөмж баталгаажуулах, Өөрийн эрхээр нэвтэрсэн төхөөрөмжүүдийг хянах хэсэг .....	ыы22
Зураг 5. Гарын авлага үзэх хэсэг .....	23
Зураг 6. СЯ-ны ТСГ-с ТСЦУС-н 2023 оны хөгжүүлэлтийн төлөвлөгөө .....	23
Зураг 7. Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 5 дугаар хавсралт. Маягт ТТ-5 .....	32

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

<b>Аудит нэр:</b>	Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл
<b>Аудитын код:</b>	<b>ӨВА-2026/14-14/ШТА-НА</b>
<b>Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:</b>	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар “Аудитын сэдэв батлах тухай” тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар баталсан "Аудитын сэдэв батлах тухай" А/173, "Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/179 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн аудитыг хийж гүйцэтгэв.
<b>Аудитын зорилт:</b>	<p>Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан Монгол Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.</p> <p>Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх;</li> <li>• Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх.</li> </ul>
<b>Аудитын хамарсан хүрээ:</b>	<p>Аудитаар Монгол Улсад төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, хууль тогтоомжийн нийцэл, аймаг, сумын Төрийн сан, Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчид, Төрийн сангийн удирдлагын цахим системийг /цаашид ТСУЦС гэх/ ашигладаг бусад төрийн байгууллагуудыг түүвэрлэн 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бүтцийн зохион байгуулалт, чиг үүрэг оновчтой эсэх, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр нөлөөнд үнэлгээ хийсэн.</p> <p>Төрийн сангийн бүтэц болон хяналтын тогтолцооны асуудлын хүрээнд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон 19 сумын санхүүгийн албыг хамруулсан үзсэн.</p> <p>Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт, данс, төлбөр тооцооны 2023-2025 оны үйл ажиллагаанд аудит хийхдээ аймаг; мөн эрсдэлийн үнэлгээ, гүйлгээний тоо, суманд хамаарах төсвийн байгууллагын тоо, санхүүгийн тайлангийн аудитын зөрчил зэргийг харгалзан үзэж сумдыг түүвэрлэн хамруулав.</p>
<b>Аудитад хэрэглэсэн арга зүй:</b>	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр

	<p>тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал” болон бусад заавар, аргачлалын дагуу аудитын зорилго, зорилт, хөтөлбөр горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p><b>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:</b></p>	<p><i>Хууль:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төсвийн тухай;</li> <li>• Төсвийн тогтвортой байдлын тухай;</li> <li>• Засгийн газрын тусгай сангийн тухай;</li> <li>• Шилэн дансны тухай;</li> <li>• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай;</li> <li>• Нягтлан бодох бүртгэлийн тухай;</li> </ul> <p><i>Засгийн газрын тогтоол:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төрийн сангийн үйл ажиллагааны журам /2023 оны 444 дүгээр тогтоол/;</li> <li>• Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам /2021 оны 51 дүгээр тогтоол/;</li> <li>• Засгийн газрын 2013 оны “Төрийн сангийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх тухай” 116 дугаар тогтоол;</li> <li>• Засгийн газрын 2014 оны “Санхүүгийн алба байгуулах тухай” 326 дугаар тогтоол;</li> <li>• Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам /2016 оны 29 дүгээр тогтоол/;</li> <li>• Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам” (Сангийн сайдын 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 162 дугаар тушаал хүчингүй болсон)</li> </ul> <p><i>Сангийн сайдын тушаал:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт /2012 оны 294 дүгээр тушаал/;</li> <li>• Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг заавар /2016 оны 431 дүгээр тушаал/;</li> <li>• “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, “төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар”, “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал /2025 оны 112 дугаар тушаал/;</li> <li>• “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар” /2024 оны 254 дүгээр тушаал/;</li> <li>• Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх заавар /2024 оны 256 дугаар тушаал/;</li> <li>• Төрийн сангийн цахим системийн заавар /2024 оны 255 дугаар тушаал/;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн үйлчилгээний төлбөрийг картаар хүлээн авах журам /Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/131 тоот тушаал/;</li> </ul> <p>Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Автомат клирин хаус системийн дүрэм /2021 оны А-128 тоот тушаал/;</li> <li>• Их дүнтэй төлбөрийн системийн дүрэм /2025 оны А-229 тоот тушаал/;</li> <li>• Монгол банкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм /2022 оны А-135 тоот тушаал/;</li> <li>• Төлбөрийн системийн журам /2023 оны А-91 тоот тушаал/.</li> </ul>
<p><b>Аудит хийх багийн бүрэлдэхүүн</b></p>	<p>Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор О.Батжаргал хянан удирдаж, аудитын менежер П.Хорлоосүрэн үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ө.Ринчинмядаг, аудитор Р.Энхзул, Д.Очирбат, Б.Нямсэмжаан нар 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 29-ний өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.</p>

**Үндсэн мэдээлэл:**

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.40-д “төрийн сангийн үйл ажиллагаа гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг” гэж тодорхойлж, мөн хуулийн 35, 36, 37, 38 дугаар зүйлд төрийн сангийн нэгдсэн данс, тогтолцоо, нийтлэг чиг үүрэг, Төв төрийн сангийн чиг үүргүүдийг хуульчилсан байна.

Өвөрхангай аймгийн хувьд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, 19 сумын Санхүүгийн алба нь нийтдээ 46 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д<sup>1</sup> заасны дагуу 2002 онд Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд шилжсэнээс системийн сайжруулалтыг хийж ирсэн бөгөөд 2023-2025 онд 6,021.9 сая төгрөгийг санхүүгийн программ хөгжүүлэлтэд зарцуулсан байна.


Зураг 1. Сангийн яамны төлбөр тооцооны системүүд



Мөн банк хоорондын системийн шинэчлэлтэд төрийн үйлчилгээний төлбөрийг олон хувилбараар төлөх нөхцөлийг бүрдүүлжээ.

<sup>1</sup> Бүх шатны төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ

Зураг 2. Банк хоорондын системийн шинэчлэлт



\*RTGS-Монгол банк дахь их дүнтэй гүйлгээний систем /5,000,001 төгрөгөөс дээш үнийн гүйлгээ/

\*RTP- Монгол банк дахь бага дүнтэй гүйлгээний систем /5,000,000 төгрөгөөс доош үнийн гүйлгээ/

\*ACH-Зөвшөөрөгдсөн гүйлгээ /Хүүхдийн мөнгө, НӨАТ-ын буцаалт, Халамжийн тэтгэвэр, тэтгэмж, ТАХ-ийн цалин/

Зураг 3. Сангийн яамны системүүд



Дээрх 12 системээс аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс 8, сумын Санхүүгийн албанд 7 системийг ашиглаж байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд системийн хэрэглэгчээр нь авч үзвэл Эрхийн бүртгэлийн болон Төрийн сангийн удирдлагын цахим системийн хувьд 202 төсвийн байгууллага, 1197 данс, 571 системийн хэрэглэгч, Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн хувьд 199 төсвийн байгууллага, 6705 цалин тооцоолж буй төрийн албан хаагч байна.

Аймгийн нэгдсэн төсвийн 2025 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл 92.8 тэрбум, зарлагын гүйцэтгэл 92.4 тэрбум, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл (0.4) тэрбум төгрөг байна.

Төрийн сангийн тогтолцооны 2013 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитын нэгдсэн төлөвлөгөөгөөр хийж гүйцэтгэн аудитаар “Өвөрхангай аймгийн Төрийн сангийн салбар, нэгжүүдийн үйл ажиллагаа үр дүнтэй байна.” гэсэн нэгдсэн дүгнэлттэй нийт 172.8 сая төгрөгийн 1 албан шаардлага, 4 зөвлөмжийг өгч байсан.

Аудитаар **512.2 сая** төгрөгийн **13** зөвлөмж өгч; **512.2 сая** төгрөгийн **1** санхүүгийн үр өгөөж, **4** санхүүгийн бус үр өгөөж тооцов.

**БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН АКТУУД ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ НИЙЦЭЖ БАЙГАА Ч СУМДЫН ТӨРИЙН САНГИЙН ТҮВШИНД ЧИГ ҮҮРГИЙН ДАВХАРДАЛ ҮҮСЭЖ БАЙГАА ТУЛ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

**1.1. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актууд холбогдох хууль тогтоомжтой нийцэж байна.**

**1.1.2. Холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэрүүд хууль тогтоомжтой нийцэж байна.**

*Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд* Эдийн засгийн бодлого, төсөв санхүүтэй холбоотой бүлэг заалтууд тусгагдсан бөгөөд аймгийн хэмжээнд хэрэгжилтийг ханган, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн дүгнүүлж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02/03 дугаар тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө
Гуравдугаар бүлэг. “Эдийн засгийн бодлого”-д төрийн бүх шатанд төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах үндсэн зорилгын хүрээнд 4 зорилт-13 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан.	Хоёрдугаар бүлэг. “Эдийн засгийн бодлого”-д төрийн бүх шатанд төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах үндсэн зорилгын хүрээнд 4 зорилт-10 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан.

Эдгээр бодлогын баримт бичгийн заалтууд төрийн сангийн үйл ажиллагаанд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжуудтай нийцсэн байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын албан даалгавар, хуралдааны тэмдэглэлээс өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хариуцан тайлагнадаг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд улирал, хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг бөгөөд 2025 онд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн хариуцан тайлагнасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг 100 хувь гэж үнэлсэн байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2025 онд дараах тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжилтийг хянан, тайлагнасан байна. Үүнд:

Тогтоол, шийдвэрийн дугаар	Заалт
УИХ-ын 2022 оны “Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 72 дугаар тогтоол	1.3.“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах”;
УИХ-ын төсвийн байнгын хорооны 2023 оны “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 5 дугаар тогтоол	бг/. “Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах”;

<p>УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 01 дүгээр тогтоол</p>	<p>1.2-д “Төсвийн тухай хуулийн 28.2.4, 29.3 дахь заалтуудын хэрэгжилтийг хангуулан МУЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаал “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангах, цахим орчинд байршуулж буй төсвийн талаарх мэдээллийг эдгээр журмуудын хавсралтад тусгасан загварт хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэх, мэдээллийг тогтоосон хугацаанд нь нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар оруулах”</p>
<p>МУЗГ-ын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл</p>	<p>13.3.7 -д “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилт, өндөр өртөгтэй автомашин, тавилга хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг хязгаарлаж, уулзалт, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллахыг төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад даалгав”;</p>

Мөн аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст 2023–2025 онд ирсэн албан бичгийн бүртгэлээс харахад цаасан суурьт албан бичиг бага ирсэн байх бөгөөд төрийн сангийн үйл ажиллагаа нь цахим системд шилжсэнтэй холбоотойгоор заавар, аргачлал, чиглэлүүд нь цахим системээр хүргэгджээ. Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн албан бичгүүд нь ихэвчлэн чиглэл хүргүүлэх, зөвлөмж өгөх, хамтран ажиллах, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, мэдэгдэл хүргүүлэх зэрэг агуулгатай бөгөөд холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.

**1.2. Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн хувьд төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц бүрдсэн бол сумдын төрийн сан чиг үүргийн давхардал үүссэн бүтэц, зохион байгуулалт оновчгүй байна.**

**1.2.1. Сумдын төрийн сангийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт оновчгүй байна.**

**Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс**

Монгол Улсын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн албаны бүтцийг Засгийн газрын 2002 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 101 дүгээр тогтоолоор төрийн сангийн тогтолцоонд шилжүүлж, тухайн үеийн Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн хэлтэс, сумын төрийн сангийн төлөөлөгч гэсэн бүтцээр хэрэгжүүлж байхаар анх тогтоосон байна.

Тус тогтоолоор аймаг, нийслэл, дүүргийн төрийн сангийн хэлтсийг дарга, ерөнхий нягтлан бодогч болон тухайн төсөвтэй харилцагч нягтлан бодогч-20 хүртэл төсөвт байгууллага тутамд нэг нягтлан бодогч ажиллахаар тооцож зохион байгуулахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгажээ. Энэхүү зохицуулалт нь одоогийн нөхцөл байдалтай нийцэхгүй байгаа бөгөөд төрийн сангийн үйл ажиллагаа нь аймгийн Засаг даргын Тамгын газрын батлагдсан бүтэц, орон тоо болон чиг үүргийн хүрээнд хэрэгжиж байна.

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” 37 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-ын бүтцэд Санхүү, төрийн сангийн хэлтэс байхаар тогтоосон. Аймгийн ЗДТГ-ын даргын 2023, 2024 оны А/18, А/01 дүгээр тушаалаар Санхүү, төрийн сангийн хэлтсийг 8 орон тоотой байхаар баталсан байна.

*Хүснэгт 1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн орон тоо*

Д/д	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Хэлтсийн дарга	Ахлах түшмэл, ТЗ-4	1
2	Төсвийн ерөнхий нягтлан бодогч	Дэс түшмэл, ТЗ-6	1
3	Төсвийн төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-7	1

4	Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-7	1
5	Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн (Улсын байцаагч)	Дэс түшмэл, ТЗ-7	1
6	Төсвийн орлого, санхүүгийн зах зээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-8	1
7	Төрийн сангийн мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-8	2
<b>Бүгд</b>			8

Бүртгэлийн мэргэжилтэн 1 удаа, төрийн сангийн мэргэжилтэн 2 удаа, төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн 2 удаа шинэчлэн томилогдсон байна.

Төсвийн орлого, санхүүгийн зах зээлийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлыг 2023 онд төсвийн төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн; төсвийн ерөнхий нягтлан бодогчийн ажлыг /хүүхэд асрах чөлөөтэй/ төрийн сангийн мэргэжилтэн болон төсвийн орлого, санхүүгийн зах зээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн тус тус хавсран гүйцэтгэсэн байна. Аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн үүргийг орлон гүйцэтгэх албан тушаалтан 3 удаа солигдсоноор ажлын ачаалал нэмэгдэх, гүйцэтгэлийн чанар, үр нөлөө буурах эрсдэлийг бий болгож байна.


### **Сумын Санхүүгийн алба**

Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор төсвийн байгууллагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн үйлчилгээ үзүүлэх, төсөв, санхүү, эдийн засаг, хөгжлийн бодлогын төлөвлөлт хариуцах чиг үүрэг бүхий сумын Засаг даргын Тамгын газрын **Санхүүгийн албыг** байгуулсан.

Засгийн газрын 2002 оны 101 дүгээр тогтоолоор суманд төрийн сангийн төлөөлөгч ажиллуулах бүтэц бий болгосон боловч уг тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулалгүйгээр шинэ бүтэц, зохион байгуулалтыг бий болгосон нь чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтын хувьд зөрүүтэй ойлголт үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Сумын санхүүгийн албаны зохион байгуулалт, орон тооны жишиг нормативыг Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор дараах байдлаар тогтоосон байна.

Дүрслэл 1. Сумын санхүүгийн албаны зохион байгуулалт



Сумын Засаг даргын Тамгын газрын бүтцэд Санхүүгийн алба байхаар тогтоосон боловч ч нягтлан бодогчид төсвийн захирагч нартаа харьяалагдаж санхүүгийн албаны бүтцэд хамааралгүй болж, сумдын төрийн сангийн үйл ажиллагаа санхүүгийн албаны бүтцээр ажиллаагүй байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар 2025 онд сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг сум тус бүрээр шинэчлэн тогтоож дараах байдлаар баталсан байна.

<p><b>Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын бүтэцэд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төсвийн ерөнхий нягтлан бодогч 1;</li> <li>• Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн 2 <b>нийт 3 орон тоо</b></li> </ul>	<p><b>Бусад 18 сумын бүтэцэд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төсвийн ерөнхий нягтлан бодогч 1;</li> <li>• Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн 1 <b>нийт 2 орон тоо</b></li> </ul>
---	---

Сумдын төрийн сангийн албан хаагчдыг Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолоор **Сум, дүүргийн төсвийн ерөнхий нягтлан бодогч; Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн** гэсэн нэршлээр төрийн захиргааны албан тушаалд хамааруулан баталжээ.

Одоогийн байдлаар сумын Засаг даргын Тамгын газрын бүтэцэд **“Санхүүгийн алба”** гэсэн бие даасан нэгж байхгүй бөгөөд төрийн сангийн нийтлэг чиг үүргийг Сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчид болох төсвийн ерөнхий нягтлан бодогч болон төрийн сангийн мэргэжилтэн хэрэгжүүлж байна.

<p>Сумдын Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтод</p>	<p>Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 онд сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоосон захирамжид</p>
<p><b>“Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч”</b></p>	<p><b>“Сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч”</b></p>

Дээрх засгийн газрын тогтоолуудаас хамааран албан тушаалын нэршил, бүтэц зохион байгуулалтын талаарх зөрүүтэй байдал үүссэн байна. Цаашлаад хууль, эрх зүйн актуудад харилцан адилгүй ялгаатай нэр томъёо хэрэглэж байгаа нь Засгийн газрын 2002 оны 101 дүгээр тогтоол, Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолуудад нэмэлт өөрчлөлт оруулж, сумдын төрийн сангийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**Сумдын төрийн сангийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт оновчгүй, хууль, эрх зүйн актуудтай нийцээгүй байна:**

Сумын Засаг даргын Тамгын газрын бүтэцэд “Санхүүгийн алба” гэсэн бие даасан нэгж байхгүй бөгөөд төрийн сангийн нийтлэг чиг үүргийг Сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчид болох Төсвийн ерөнхий нягтлан бодогч **болон** төрийн сангийн мэргэжилтэн хэрэгжүүлж байна. Иймд Засгийн газрын 2002 оны 101 дүгээр тогтоол, Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолуудад нэмэлт өөрчлөлт оруулж, сумдын төрийн сангийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлагатай байна.

**1.2.2. Сумдын Төсвийн ерөнхий нягтлан бодогч болон төсөв, төрийн сангийн мэргэжилтний зарим чиг үүрэг нь давхардсан, албан тушаалын тодорхойлолтод оновчтой тусгаагүй, төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй бүрэн нийцээгүй байна.**

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ, ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААР

### Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 11-


ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 335 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/153 дугаар тушаалаар баталсан байна.

**САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА,  
МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОТДО  
ЗААСАН ЧИГ ҮҮРГҮҮДИЙГ АВЧ ҮЗВЭЛ:**



**Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын** албан тушаалын тодорхойлолтыг 5 зорилтын хүрээнд 16 чиг үүргийг хэрэгжүүлэхээр;  
**Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн** албан тушаалын тодорхойлолтыг 4 зорилтын хүрээнд 18 чиг үүргийг хэрэгжүүлэхээр;  
**Төсвийн төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтний** албан тушаалын тодорхойлолтыг 4 зорилтын хүрээнд 17 чиг үүргийг хэрэгжүүлэхээр;  
**Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтний** албан тушаалын тодорхойлолтыг 3 зорилтын хүрээнд 18 чиг үүргийг хэрэгжүүлэхээр;  
**Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтний (Улсын байцаагч)** албан тушаалын тодорхойлолтыг 4 зорилтын хүрээнд 23 чиг үүргийг хэрэгжүүлэхээр;  
**Төсвийн орлого, санхүүгийн зах зээл хариуцсан мэргэжилтний** албан тушаалын тодорхойлолтыг 4 зорилтын хүрээнд 13 чиг үүргийг хэрэгжүүлэхээр;  
**Төрийн сангийн мэргэжилтний** албан тушаалын тодорхойлолтыг 3 зорилтын хүрээнд 17 чиг үүргийг хэрэгжүүлэхээр тус тус баталсан байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүдээс албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь Төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэг эсэх талаарх санал асуулгыг авахад 7 албан хаагч хамрагдаж 100 хувь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй бүрэн нийцдэг гэж хариулсан байна.



Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь төрийн сангийн тогтолцоонд 2002 онд шилжсэн үеэс эхлэн хэлтсийн чиг үүргээр төрийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бөгөөд албан хаагчдын чиг үүрэг давхардалгүй, албан тушаалын тодорхойлолттой нийцсэн байна.

Харин цахим системд шилжсэнтэй холбоотойгоор Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар” болон албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн дансны эрх нээх ажлыг Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан ажил үүргийн хуваарьт төсвийн ерөнхий нягтлан бодогч хариуцахаар заасан байдаг. Гэвч 2017 оноос 2025 оны 10 сар хүртэл уг ажлыг төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэнд хариуцуулж ирсэн бөгөөд 2025 оны 10 дугаар сараас эхлэн орон нутгийн төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн нэмэлт санхүүжилтийн дансны эрхийг нээхээр цахим системд хөгжүүлэлт хийсэн байна.
- Төрийн сангийн эрхийн бүртгэлийн цахим системд баримт бичгийн тохиргоо хийх, хэрэглэгчийн эрх үүсгэх, тохируулж олгох зэрэг ажлуудыг төрийн сангийн мэргэжилтэн хэрэгжүүлж байгаа боловч эдгээр чиг үүргийг ажил үүргийн жишиг заавар болон албан тушаалын тодорхойлолтод тусгаагүй байна.
- Төсөвт байгууллагын төрийн сан дахь данс нээх, хаах, өөрчлөх хүсэлтийг төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн хянахаар цахим системийн хөгжүүлэлт хийгдсэн боловч уг чиг үүрэг нь мөн ажил үүргийн жишиг заавар болон албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй байна.

Иймд цахим системийн хэрэглээ, чиг үүргийн өөрчлөлттэй уялдуулан Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар” болон албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, бодитоор хэрэгжүүлж буй ажил үүргийг тусган боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

### **Сумын Санхүүгийн алба**

Сумдын Төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 208 дугаар тогтоолыг үндэслэн 19 сумын Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар шинэчлэн баталсан байна.


**Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогчийн** албан тушаалын тодорхойлолтыг 4 зорилтын хүрээнд 46 чиг үүргийг хэрэгжүүлэхээр баталсан байна.

#### **САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА БУЮУ ТӨСВИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО**



Төсөв санхүүгийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, сумын төсөвт байгууллагын төсвийн орлого, зарцуулалтын үйл ажиллагаа, төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, удирдлагад мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлж, бодит мэдээ, мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг сумын Засаг даргын өмнө хариуцан тайлагнана.

Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг Төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэг эсэх санал асуулгад 19 сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч хамрагдаж 68.0 хувь нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэггүй гэж хариулсан байна.



### **Төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцэхгүй байгаа албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг авч үзвэл:**

- 1.6. Татварын орлогыг хууль тогтоомж, шийдвэрийн дагуу татварын асуудал хариуцсан төрийн байгууллагатай хамтран ажиллаж төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах, орлогын тогтвортой бааз суурьтай болгох судалгаа, мэдээллийн сан бий болгох; /Албан тушаалын тодорхойлолтын 3.5 дахь заалт буюу Сумын төсвийн орлого бүрдүүлэхтэй холбоотойгоор татварын байцаагчийг шуурхай удирдлагаар хангах ажлыг хийдэг бөгөөд дээрх 1.6 дахь ажил үүргийг гүйцэтгэдэггүй/
- 1.9. Төсвийн тухай хуулийн дагуу нэмэлт төсвийн эрхийг байгууллагад хянан олгох; /Сумын төсвийн ерөнхий нягтлан бодогчоор дамждаггүй, аймгийн Төрийн сангийн төсвийн ахлах мэргэжилтэн хянан баталж эрх олгодог/
- 1.13. Төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, төсвийн байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж зөвлөн туслах, сургалт хийх;
- 2.9. Төсөвт байгууллагуудын жижиг мөнгөн сангийн тайланг хянах; /Төсөвт байгууллагад жижиг мөнгөн сангийн данс байхгүй хаагдсан/
- 2.15. Сумын хэмжээнд төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах;

- 2.1. Орон нутгийн төсвийн байгууллагын урамшууллын тооцоог холбогдох журмын дагуу хийх, хуваарилах, санхүүжилт олгох; /төсөвт байгууллагын урамшуулал тооцоо хийдэггүй/
- 3.1. Орон нутгийн хөгжлийн сан тусгай зориулалтын шилжүүлэг сумын нэгдсэн төсвийн төлөвлөлт хуваарилалтыг хийх, 2 дугаар гарын үсэг зурах; /ОНХС-ийн журмаар Засаг даргын тамгын газрын нягтлан 2 дугаар гарын үсэг зурдаг/
- 3.2. Төсвийн сар, улирлын хуваарийг үндэслэн төсвийн байгууллагуудын дансанд санхүүжилт болон зарцуулалтын эрх олгох; /Зарцуулах эрх олгодоггүй/
- 3.4. Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль тогтоомж, шийдвэр, бодлогын баримт бичиг болон холбогдох үйл ажиллагааны тайлан, мэдээг боловсруулах, нэгтгэн тайлагнах, холбогдох байгууллагад дурдсан хугацаанд хүргүүлэх;

**Сумдын Төсвийн ерөнхий нягтлан бодогчид нь албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй дараах чиг үүргүүдийг гүйцэтгэж байна. Үүнд:**

- Төсвийн төсөөллийг бэлтгэн хүргүүлэх ажил;
- Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороо, орон тооны бус зөвлөлүүдэд гишүүнээр ажиллах;
- Худалдан авах ажиллагаа, ажлын гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг бэлтгэх зэрэг ажлуудыг давхар гүйцэтгэж байна.
- Худалдан авах ажиллагааг давхар хариуцан төлөвлөгөө, тайлан боловсруулах, үнэлгээний хороонд ажиллах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг./Энэ нь хяналтын хараат бус байдал алдагдах нөхцөл бүрдүүлдэг./

2025 онд шинэчлэн батлагдсан Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг авч үзэхэд албан хаагчийн хэрэгжүүлж буй чиг үүргийг бүрэн судалж, холбогдох хууль тогтоомж, журамтай нарийвчлан уялдуулаагүй боловсруулсан нь судалгааны дүнгээс харагдаж байгаа тул чиг үүргийг холбогдох журам, зохицуулалттай нийцүүлж боловсруулах шаардлагатай байна.

Түүнчлэн Төсвийн ерөнхий нягтлан бодогч, төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод **“Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн мэдээлэх”, “Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх”** зэрэг агуулгын хувьд ижил төстэй, давхардсан чиг үүргүүдийг тусгасан нь албан тушаалын тодорхойлолтын чиг үүргийг боловсруулахдаа нэгдсэн зохион байгуулалт, нарийвчилсан судалгаа дутмаг байсныг илэрхийлж байна.

#### **Сумын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн**


Албан тушаалын тодорхойлолтыг 5 зорилтын хүрээнд 23 чиг үүргийг хэрэгжүүлэхээр баталсан байна.

#### **ТӨСӨВ, ТӨРИЙН САНГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО**



Нутаг дэвсгэрийн хэмжээнд төсөв санхүүгийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн байгууллагуудад төрийн сангийн үйлчилгээ үзүүлэх, статистик мэдээллийг хариуцан ажиллаж, ажлын гүйцэтгэлийн үр дүнг сумын Засаг даргын Тамгын газрын даргын өмнө хариуцан тайлагнана.

Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг Төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцэж байгаа эсэх талаар явуулсан санал асуулгад 19 сумын Төсөв, төрийн сангийн 20 мэргэжилтэн хамрагдсан байна. Судалгааны үр дүнд оролцогчдын 10 буюу 50 хувь нь албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүрэг төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэггүй гэж хариулсан нь чиг үүргийн уялдаа, зохицуулалт хангалтгүй байгааг харуулж байна.



**Төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцэхгүй байгаа албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг авч үзвэл:**

- 1.1. Монгол улсын Алсын хараа- 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн орон нутагт хамааралтай зорилтуудыг хяналтад авч, хэрэгжилтийг хангах;
- 2.2. Аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд цахимаар илгээж байгаа эсэхэд хяналт тавих, тайланг нэгтгэх; /Хяналт тавьж тайлан нэгтгэх боломжгүй, тайлан харах эрх сумдад байхгүй/
- 3.5. Татварын орлогыг хууль тогтоомж, шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулахад Татварын албатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх; /зарим сумдад татварын мэдээлэл нь хувь хүний мэдээлэл тул гаргаж өгөх боломжгүй хэмээн мэдээлэл солилцох явц удааширдаг асуудал байдаг/
- 4.1. Сумын статистик мэдээ тайлан, тооллого судалгаа, мэдээллийн санг хөтөлж, тайлан мэдээллийг гаргах;
- 4.2. Сумын статистик мэдээ, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангаж, мэдээ, мэдээллээр холбогдох албан тушаалтан, байгууллага, иргэнийг хангах;
- 5.2. ХАБЭА-н тухай хуулийн сургалт, зөвлөгөөнд идэвхтэй оролцох, осолд өртсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах талаар ХАБЭА-н ажилтанд мэдээлэх, хамтран ажиллах.

**Сумдын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй дараах чиг үүргүүдийг гүйцэтгэж байна. Үүнд:**

- Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд дарга, нарийн бичиг, гишүүнээр ажиллах;
- Шүүхийн шийдвэрээр хураагдсан тээврийн хэрэгсэл, эд зүйлийн үнэлгээ тогтоох, борлуулах, орлогыг төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн нарийн бичиг
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хариуцаж төсөл үүсгэн, иргэдээс санал авч, бодлогын баримт бичигтэй уялдуулан, холбоотой материалуудыг боловсруулж хавсаргадаг, үнэлгээний асуултад хариулах, бэлэн байдлын үнэлгээ хийж, илгээдэг.

Мөн албан тушаалын тодорхойлолтын **5.1, 5.2, 5.6** дахь чиг үүргүүдийн агуулга хоорондоо давхацсан, ижил төстэй байдлаар тусгагдсан нь чиг үүргийн уялдаа, ялгамжтай байдлыг хангалтгүй боловсруулсныг харуулж байна.

**Хавсран хийж буй статистикийн ажлын талаар**

Төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүд статистикийн 12 мэдээг сар, улирал, хагас жил, жилийн давтамжаар гаргах ажлыг албан үүргийн хувьд голлон хийж байгааг талбарт ажиллах явцад мэргэжилтнүүд онцолж байв. Үүнээс гадна төлөвлөгөөт бус судалгаа, тодруулгын шинжтэй ажлууд байнга ирдэг нь ажлын ачааллыг нэмэгдүүлдэг талаар дурдсан. Сумын хүн ам, аж ахуй нэгж, малын тоо их байх тусам ачаалал их байдаг.

**Тухайлбал:** Бат-Өлзий сум байнгын болон түр оршин суугчдыг хамруулан 8, Уянга сум 10 мянга, Хужирт сум 7 мянга, Богд сум 6 мянга гаруй хүн амтай.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 40 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод сумын статистик мэдээллийг хариуцахаар үндсэн чиг үүрэгт нь зааснаас хойш статистикийн ажил хавсран гүйцэтгэсний 20 хувийн нэмэгдлийг авах эрх зүйн үндэсгүй болсон нь харагдаж байгаа ч Үндэсний статистикийн хорооны дарга, сангийн сайдын хамтарсан 2012 оны 1/48,88 дугаар тогтоол нь хүчингүй болоогүй байгаа гэх үндэслэлээр нэмэгдлийг олгосоор байна.

Мөн Үндэсний статистикийн хорооны 2021 оны үйл ажиллагааны тайланд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 40 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод сумын статистик мэдээллийг хариуцахаар үндсэн чиг үүрэгт нь зааснаас хойш нэмэгдэл цалин, урамшууллыг олгохыг зогсоосон талаар дурдсан байна. Нэмэгдлийн талаар аймгийн статистикийн хэлтсээс тодруулахад улсын хэмжээнд бүх сумдын Төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүд 20 хувийн нэмэгдлийг Үндэсний статистикийн хорооны дарга, сангийн сайдын хамтарсан тушаал хүчинтэй байгаа тул авч байгаа гэсэн тайлбар өгсөн.

Албан тушаалын тодорхойлолт шинэчлэхэд сумдын зүгээс санал өгсөн боловч тус саналууд нь тусгагдаагүй байна.

**ДАВХАР БОЛОН ХАВСРАН ГҮЙЦЭТГЭЖ БУЙ АЖЛУУДЫН ТАЛААР**

Төрийн сан хариуцсан албан хаагчдын давхар ажил эрхлэлт манай аймгийн хувьд харьцангуй бага байгаа бөгөөд 2023–2025 оны судалгааны үр дүнгээс үзэхэд аймгийн Төрийн сангийн хэлтсийн албан хаагчид ихэвчлэн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэгтэй ойролцоо албан тушаалын чиг үүргийг хавсран гүйцэтгэж байсан байна.

**Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн албан хаагчдын хавсран гүйцэтгэсэн албан тушаалын судалгаа /2023-2025 он/**

- Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн ахлах мэргэжилтэн **2023 онд Төсвийн орлого хариуцсан мэргэжилтний үүргийг;**
- Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн Төрийн сангийн мэргэжилтэн **2024 онд аймгийн Ерөнхий нягтлан бодогчийн;**
- Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн **2025 онд аймгийн Ерөнхий нягтлан бодогчийн чиг үүргийг тус тус хавсран гүйцэтгэж байсан байна.**

Харин сумдын төрийн сангийн албан хаагчдын хувьд албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээс өөр, тухайлбал хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн, хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны байцаагч зэрэг албан тушаалын чиг үүргийг хавсран гүйцэтгэсэн байна.

Зарим сумдад Санхүү, албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн жилд 2-оос дээш удаа солигдох, жил бүр мэргэжилтэн солигдох зэрэг хүний нөөцийн тогтворгүй байдал үүссэн байна.

**Тухайлбал:** Хархорин суманд Санхүүгийн албаны дарга 2023 онд 3 удаа, 2025 онд 2 удаа, Төрийн сангийн мэргэжилтэн 2023-2024 онд тус бүр 2 удаа; 2023-2025 онд Есөнзүйл суманд Санхүүгийн албаны дарга 3 удаа, Богд, Хайрхандулаан сумд мэргэжилтэн 3 удаа солигдсон байна.

Мөн сумдын санхүү албаны дарга, төрийн сангийн мэргэжилтнийг орлон ажиллах албан тушаалтан нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр ажилласан туршлагагүй байгаа нь гүйлгээний хяналтын чанар муудах эрсдэлийг дагуулж байгаа бөгөөд цаашид Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 1.1.2-т заасны дагуу төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажил үүргийн хуваарийг батлуулж хэвших, мөн ажил үүргийн хуваарийн дагуу орлон ажиллах албан тушаалтныг тодорхой болгох шаардлагатай байна.

Түүнчлэн зарим сумдад Санхүү албаны дарга төсвийн нягтлан бодогчийг давхар хавсран гүйцэтгэсэн, өөрийн хийсэн гүйлгээнд хяналт хэрэгжүүлж байсан /ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй/ асуудлууд гарч байсан бөгөөд 2024 оноос энэ асуудал байхгүй болсон байна.

**Сумдын төрийн сангийн албан хаагчдын хавсран гүйцэтгэсэн албан тушаалын судалгаа /2023-2025 он/**

- Баруунбаян-Улаан сумын Улсын бүртгэгч **2023-2024 онд Төрийн сангийн мэргэжилтний үүргийг;**
- Богд сумын Санхүүгийн албаны дарга **2023 онд Төрийн сангийн мэргэжилтний үүргийг;**
- Богд сумын Нийгмийн даатгалын байцаагч **2025 онд Төрийн сангийн мэргэжилтний үүргийг;**
- Гучин-Ус сумын Санхүүгийн албаны дарга **2023 онд Төрийн сангийн мэргэжилтний үүргийг;**
- Гучин-Ус сумын Төрийн сангийн мэргэжилтэн **2024 онд Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний, 2025 онд Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг;**
- Гучин-Ус сумын Санхүүгийн албаны дарга **2025 онд Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг;**
- Өлзийт сумын Төрийн сангийн мэргэжилтэн **2023 онд байгаль орчны байцаагчийн, 2024-2025 онд ХАА мал үржил хариуцсан мэргэжилтэн, ХАА бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтний үүргийг;**
- Төгрөг сумын Төрийн сангийн мэргэжилтэн **2023 онд Санхүүгийн албаны даргын үүргийг;**
- Уянга сумын Төрийн сангийн мэргэжилтэн **2023 онд Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн нягтлан бодогчийн, 2024-2025 онд Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг;**
- Хархорин сумын Төрийн сангийн мэргэжилтэн **2023-2024 онд Татварын улсын байцаагчийн үүргийг тус тус хавсран гүйцэтгэж байсан байна.**

Судалгааны үр дүнгээс харахад сумдын түвшинд хүний нөөцийн хүрэлцээ хангалтгүй байгаагаас шалтгаалан төрийн сангийн албан хаагчид мэргэжлийн бус болон үндсэн чиг үүрэгт хамааралгүй ажлыг давхар гүйцэтгэх нөхцөл байдал үүссэн. Сумын төрийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг сайжруулан, чанаржуулахын тулд санхүү албаны дарга, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод ажлын туршлагыг нарийвчлан тусгаж, мэргэжлийн шаардлага тусгах хэрэгтэй юм.

**АЖЛЫН АЧААЛАЛ**

Аймаг, сумдын Төрийн сангийн албан хаагчдын ажлын ачаалал нь гүйлгээ батлах төсөвт байгууллага, сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, мөн суманд бүртгэлтэй тайлан баталгаажуулдаг аж ахуйн нэгжийн тооноос шалтгаалан харилцан адилгүй байна.

байгууллага болон аж ахуйн нэгжийн тоо их, хянаж баталгаажуулдаг гүйлгээний тоо өндөртэй аймаг, Арвайхээр, Хархорин, Уянга, Хужирт зэрэг сумдын Төрийн сангийн албан хаагчдын ажлын ачаалал харьцангуй өндөр байна.

Хянаж баталгаажуулсан гүйлгээний тоог сараар авч үзвэл 1 дүгээр сард хамгийн бага, харин 6 болон 9-12 дугаар сард хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Мөн 2025 онд төсвийн санхүүжилт буурсантай холбоотойгоор хянаж баталгаажуулсан гүйлгээний тоо 2024 онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Сумдын хянаж буй гүйлгээний тоо, төсөвт байгууллага, сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, суманд бүртгэлтэй аж ахуй нэгжийн тоог харуулбал /хүн ам олонтой Арвайхээр Бат-Өлзий, сумдад орон нутгийн хөгжлийн сан хариуцсан тусдаа нягтлан бодогч ажиллаж байна./:

*Хүснэгт 2. Аймаг болон сумдын Төсөвт байгууллага, Сан, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, суманд бүртгэлтэй аж ахуй нэгжийн тоо*

№	Сумын нэр	Сард хянаж буй гүйлгээний тоо /12 сарын дунджаар/			Төсвийн байгууллагын тоо	Сангуудын тоо	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тоо	Суманд бүртгэлтэй ААН-ийн тоо /тайлан баталгаажуулдаг/		
		2023	2024	2025				2023	2024	2025
1	Аймаг	2463	2890	2472	44	4	5			
2	Арвайхээр	1054	1045	1533	22	2	3	527	629	743
3	Баруунбаян-Улаан	236	241	216	6	2		23	34	46
4	Бат-Өлзий	318	386	414	9	2	1	100	98	121
5	Баян-Өндөр	252	263	221	6	2		45	69	65
6	Баянгол	232	256	242	6	2		12	39	40
7	Богд	335	350	326	8	2		16	51	41
8	Бүрд	242	258	228	6	2		14	18	14
9	Гучин-Ус	276	269	250	6	2		30	34	52
10	Есөнзүйл	227	244	217	6	2		16	20	25
11	Зүүнбаян-Улаан	238	267	225	6	2		15	14	32
12	Нарийнтээл	368	331	317	8	2		21	27	27
13	Сант	246	235	226	6	2		30	48	56

14	Тарагт	255	282	259	7	2		28	35	55
15	Уянга	463	477	452	10	2	1	47	67	90
16	Хайрхандулаан	235	262	225	6	2		33	21	19
17	Хархорин	1129	1245	1133	22	2	1	161	173	180
18	Хужирт	403	448	445	10	2	1	44	70	76
19	Өлзийт	230	251	218	6	2		10	19	18
20	Төгрөг	248	263	245	6	2		18	19	17
<b>Нийт</b>		<b>9450</b>	<b>10263</b>	<b>9864</b>	<b>206</b>	<b>42</b>	<b>12</b>	<b>1190</b>	<b>1485</b>	<b>1717</b>

Цаг үеийн ажлууд, хог арилгах, өвс буулгах, малын тооноор татвар хураах, баяр наадам, сумын онцгой комисст ажиллах, цэрэг татлагын комисс, цэргийн бүртгэлд ажиллах зэрэг нь албан бус байдлаар сумдын төрийн сангийн албан хаагчдын хамран оролцох ажил их байдаг.

Аудитын явцад нийт аймаг, сумдын төрийн сангийн нийт 28 албан хаагчдаас Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой цахим асуулгыг нэмэлтээр авч, дүнг нэгтгэсэн. Тус асуулгаар “Төрийн сангийн үйл ажиллагаа цахимжсанаар гүйлгээ болон хянах батлах ажиллагаа цахимаар хийгдэх болсон нь цаг хугацаа хэмнэж, ажлын ачаалал тодорхой хэмжээгээр буурсан. Мөн санхүүгийн тайлангийн үлдэгдэл, гүйцэтгэлийн тайланг шууд татах боломж бүрдсэнээр цаасан баримт багассан. Анхан шатны баримт бүрдүүлэлт илүү үнэн зөв, түргэн шуурхай болж, байгууллагын удирдлагууд байхгүй үед тамга, гарын үсэг хүлээгдэх асуудал арилсан. Түүнчлэн цахим архив үүссэнээр мэдээлэл хадгалалт, хяналт сайжирч, хаанаас ч ажиллах боломж нэмэгдсэн зэрэг олон эерэг өөрчлөлт гарсан.” Гэсэн байна.

Аудитын явцад сумдын төрийн сангийн мэргэжилтнүүд төрийн сангийн гүйлгээний хяналтад ачаалал үүсгэж байгаа асуудлын нэг нь нэг байгууллагын нягтлан бодогч олон ажил хавсран гүйцэтгэдэг, авч буй нэмэгдэл хөлсний хэмжээ харилцан адилгүй байдаг нь тэдгээрийн ажлын гүйцэтгэл, чанарт нөлөөлдөг эрсдэл их байлаа.

Аймгийн хэмжээнд 206 төсөвт байгууллагад 157 нягтлан бодогч ажиллаж байгаа бөгөөд үүнээс:

- 1 байгууллага хариуцдаг 109,
- 2 байгууллага хариуцдаг 43,
- 3 байгууллага хариуцдаг 5 нягтлан бодогч байна. Эдгээр ажлын давхардлаас шалтгаалж ажлын үр дүн буурах эрсдэлтэй байна.

Давхар ажил эрхэлж буй нягтлан бодогч нарын нэмэгдэл хөлсний хэмжээг Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д “Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно” хэмээн заасны дагуу харилцан адилгүй олгож байна. Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсний хэмжээг харвал:



**Дээрх нөхцөл байдлаас нийтэд нь дүгнэн үзэхэд** сумдын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын чиг үүрэг, статистикийн ажлын зохион байгуулалт, нэмэгдэл олгох эрх зүйн зохицуулалтын уялдаа хангалтгүй байна. Тухайлбал, статистикийн мэдээлэл боловсруулах, тайлагнах чиг үүргийг албан тушаалын үндсэн чиг үүрэгт 2019 оноос хойш тусгасан атлаа статистикийн ажлыг хавсран гүйцэтгэсний 20 хувийн нэмэгдлийг өмнөх хамтарсан тушаалыг үндэслэн үргэлжлүүлэн олгож байгаа нь эрх зүйн зохицуулалтын зөрүүтэй байдал үүсгэж байна.

Мөн сумдын мэргэжилтнүүд статистикийн олон төрлийн мэдээ, тайлан боловсруулах, төлөвлөгөөт бус судалгаа, тодруулгын ажил гүйцэтгэхэд ихээхэн цаг зарцуулж байгаа нь төрийн сангийн үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх, хяналт шалгалтыг чанартай хийх боломжийг хязгаарлаж байна. Үүний улмаас ажлын ачаалал нэмэгдэх, хяналтын зарим чиг үүргийг дутуу хэрэгжүүлэх эрсдэл үүсэж байгаа нь судалгаа, ярилцлагын үеэр тогтоогдсон тул төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолтоос статистик мэдээ, тайлан хариуцах ажлыг салгаж үндсэн чиг үүргийнх нь ажлыг хийлгэснээр төрийн сангийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх үндсэн зорилт хэрэгжиж, хяналт сайжрах боломж бүрдэнэ.

Иймд Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолт, статистикийн чиг үүрэг болон нэмэгдэл олгохтой холбоотой эрх зүйн актуудын уялдаа холбоог дахин нягтлан сайжруулах, чиг үүргийн давхардал, ачааллыг бууруулах, төрийн сангийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Мөн Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч, Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь сумын Засаг даргын Тамгын газрын бүтцэд хамаарч байгаа хэдий ч гүйцэтгэлийн үр дүн, хариуцлагын тогтолцооны хувьд ялгаатай зохицуулалттай байна. Тухайлбал, төсвийн ерөнхий нягтлан бодогч нь гүйцэтгэлийн үр дүнгээ сумын Засаг даргын өмнө, харин Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь Засаг даргын Тамгын газрын даргын өмнө хариуцахаар тус тус зохицуулсан нь удирдлага, хяналт, хариуцлагын тогтолцоонд зөрүүтэй байдал үүсгэж байна.

Давхар ажил эрхлэлтийн судалгааны үр дүнгээс үзэхэд төрийн сан хариуцсан албан хаагчдын давхар ажил эрхлэлт аймгийн түвшинд харьцангуй бага давхацсан бөгөөд ихэвчлэн үндсэн чиг үүрэгтэй ойролцоо ажил хавсран гүйцэтгэдэг. Харин сумдын түвшинд хүний нөөцийн хүрэлцээ хангалтгүй байгаагаас төрийн сангийн албан хаагчид үндсэн чиг үүргээс өөр, мэргэжлийн бус ажлыг давхар хариуцах нөхцөл үүссэн нь төрийн сангийн үйл ажиллагааны мэргэшсэн, тогтвортой байдлыг сулруулах эрсдэлтэй байна.

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 208 дугаар тогтоолоор баталсан сумдын төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай.
- Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын чиг үүрэг, статистикийн ажлын зохион байгуулалт, нэмэгдэл олгох эрх зүйн зохицуулалтын уялдаа хангалтгүй байна. Статистикийн ажил албан тушаалын чиг үүрэгт орж ирснээр сумдын мэргэжилтнүүд төрийн сангийн үндсэн үйл ажиллагааны чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.
- Санхүүгийн сахилга батыг сайжруулах, эрсдэл, зөрчлийг бууруулахын тулд нэг талаас гүйлгээнд хяналт тавьж буй мэргэжилтэн, албаны дарга нарийг чадавхжуулах, албан тушаалд тавигдах шаардлагыг харгалзан үзэх, нөгөө талаас хавсран ажиллаж буй нягтлан бодогч нарын хариуцлагын асуудлыг авч үзэх шаардлага үүсээд байна.

### 1.2.3. Төрийн сангийн цахим системийн удирдлага, зохицуулалт, мэдээллийн аюулгүй байдал, хэрэгцээ шаардлага нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйл Төрийн сангийн нийтлэг чиг үүргийн 37.1.5.-д “төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих” гэсэн заалтын дагуу Сангийн

яамны Төрийн сангийн газраас “Төрийн сангийн удирдлагын цахим систем” -ийг нэвтрүүлсэн. Мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.4. “төрийн сангийн үйл ажиллагааны журам, зааврыг боловсруулж хэрэгжүүлэх” чиг үүргийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төв хэрэгжүүлнэ гэж заасны дагуу МУЗГ-н 2023 оны 444 дүгээр тогтоолоор “Төрийн сангийн үйл ажиллагааны журам” -ыг шинэчлэн баталж, хэрэгжүүлж байна.

Сангийн яамны Төрийн сангийн газраас дараах системүүдийг холбогдох байгууллагаар хөгжүүлж аймаг, сумын төрийн сан болон төрийн байгууллагуудад ашиглаж байна. Үүнд:  
*Хүснэгт 3. Аймаг, сумдын төрийн сан, төрийн байгууллага ашигладаг СЯ-ны систем.*

№	Системийн нэр /нэршил/	Аймаг	Сум	Байгууллага
1	Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем	+	+	
2	Эрхийн бүртгэлийн сан /finance/ <i>Төсвийн байгууллага бүртгэх, тухайн хэрэглэгчийн эрхийг тохируулах систем</i>	+	+	
3	Төрийн сангийн удирдлагын цахим систем /finance/ <i>Төсвийн байгууллагын нягтлан бодогчдод зориулсан санхүүгийн гүйлгээний систем</i>	+	+	+
4	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем /payroll/	+		+
5	Багцын гүйлгээний систем	+		
6	Төсвийн байгууллагын төлөвлөлтийн систем /Piscal/	+		
7	Төсвийн байгууллагын тайлангийн систем /Finperform/	+	+	+
8	Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүгийн нэгдсэн систем /PIMIS/	+		
9	Төрийн сангийн дансны хуулга, тайлан татах систем /Ehuulga/	+	+	+
10	Цахим санхүүгийн тайлангийн систем /Ebalance/	+		+
11	Шилэн данс /Shilendans/	+	+	+

\* систем ашиглалтыг (+)-р тэмдэглэв.


Мэдээллийн аюулгүй байдлыг систем талаас ашигласан фрэймворк, кодчиллыг үзэх бөгөөд эдгээр асуудлыг төв төрийн санд Үндэсний аудитын газар үзэж шалгана. /Системийн хувьд зөв хэрэглэгч нэвтэрч байгаа эсэхийг хянах, тухайн нэвтэрсэн хэрэглэгчид үзэж болох мэдээллийг үзүүлэх нь системийн асуудал юм./ **Хэрэглэгчээр дамжуулж системийн мэдээлэл алдагдах эрсдэлийг** хэрэглэгч өөрөө хариуцдаг.

Хэрэглэгч системүүдэд нэвтрэх үед нэр, нууц үг, нэвтэрч буй төхөөрөмж нь бүртгэлтэй эсэх мэдээллийг шалгадаг. Төрийн сангийн системүүдийн хувьд Гааль, татварын санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-аас нэвтрүүлсэн “Нэвтрэлтийн нэгдсэн систем” (<https://auth.itc.gov.mn>)-г ашиглаж байна. Энэ систем нь хэрэглэгчдэд ашиглалт болон аюулгүй байдлын хувьд дараах давуу талуудыг бий болгожээ. Үүнд:

- Хэрэглэгчийг татварын мэдээллийн баазтай танин баталгаажуулах;
- Бүртгэлгүй төхөөрөмжөөр нэвтрэх үед давхар баталгаажуулалт хийх;
- Системд нэвтэрч орсны дараа эрхийн шатлалаас хамаарч хандаж болох системүүд нэгдсэн байдлаар харагдаж хоорондоо шилждэг;
- Нэгдсэн байдлаар системд нэвтэрснээр хэрэглэгч олон хаяг тогтоох шаардлагагүй болгож хялбарчилсан, өөрийн эрхээр нэвтэрсэн төхөөрөмжүүдээ хянах боломжтой болсон.


Харин хэрэглэгч ННС-г ашиглаж нэвтрэх үедээ ямар мэдээллээ системүүдэд өгч байгаагаа мэдэх боломжгүй байна.

*Зураг 4. Төхөөрөмж баталгаажуулах, Өөрийн эрхээр нэвтэрсэн төхөөрөмжүүдийг хянах хэсэг*



Аудитын явцад системүүдийн ажиллагаа болон эцсийн хэрэглэгч нарын ашиглалтыг үзсэн. Системүүдийн ашиглах гарын авлага файл болон бичлэг хэлбэрээр байршсан, тухай бүр шинэчлэгдэж байгаа нь шинэ албан хаагчийн хувьд хүнээс хүнд бус системээс хүнд гэсэн зарчмаар явж байна.

Зураг 5. Гарын авлага үзэх хэсэг



Эцсийн хэрэглэгч /СТСХ-ийн мэргэжилтнүүд, байгууллагын дарга болон нягтлан бодогч/ систем ашиглах үед илрүүлсэн алдаа, системд оруулах сайжруулалт, засварын санал өгөх хэсэг байхгүй. Үүнтэй холбоотой систем хөгжүүлэгч байгууллага болох Гааль, татварын санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ, Сангийн яамтай баталгаажуулсан төлөвлөгөөний дагуу эргэх холбоо буюу хэрэглэгчээ сонсох хэсгийг 2023 оноос хойш үе шаттайгаар нэвтрүүлэх ажил хийгдэж, 2026 онд туршиж эхэлсэн байна.

Зураг 6. СЯ-ны ТСГ-с ТСЦУС-н 2023 оны хөгжүүлэлтийн төлөвлөгөө

Д.а	АЖИМН ЯАГСААЛТ	систем	Хөгжүүлэлтийн тайлбар	Ажлын хэзэвр	Хугацаа												
					6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-дугаар сар	12-дугаар сар	2024 оны 1-р сар	2024 оны 2-р сар	Төлөвлөгөө			
1.9	Хүснэгтийн нэмэлт																
1.9.1	Төрийн байгууллагын цахим системийн өрсөлдөөн нэмэлтийн хэсэг	ТСУС	НОМӨЛТ - БОДЛОГО	Шинэ хөгжүүлэлт -													
1.9.2	Дамжир бүртгэлийн модуль ИТСУМС, Бизнесэд дано занвар өгөх, илгээх үйлчилгээний хэсэг	ТСУС	НОМӨЛТ - БОДЛОГО	Шинэ хөгжүүлэлт -													
1.9.3	Хэрэглэгчийн туслах ажил хөгжүүлэх /сэрвэлгээг системд гаргах арга, санал, гондлаг авах, нэгтгэх/	ТСУС	ЭЦЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ӨРӨГӨГҮЙ	Шинэ хөгжүүлэлт -													

Эх сурвалж: Сангийн яам, Төрийн сангийн газар

**Аймаг, 19 сумдын төрийн сангийн нийт 40 мэргэжилтнээс** “Төрийн сангийн цахим системийн ашиглалтын талаарх” судалгаа авч нэгтгэсэн. Судалгааны дүнг нэгтгэн дүгнэхэд:

**Асуулт 1:** “Төрийн сангийн үйл ажиллагааг явуулахад цахим систем таны ажлын хэрэгцээг хэр хангаж байна вэ?” асуултад “Бүрэн хангаж байна” гэж 28, “Хэвийн хангаж байна” гэж 12, “Хангалтгүй байна” гэж 0 оролцогч ирүүлсэн байна. Үүнээс Төрийн сангийн цахим системүүд хэрэглэгчийн шаардлагыг 100% хэвийн хангаж чаддаг гэж дүгнэх боломжтой байна.



**Асуулт 2:** “Цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ?” асуулгын дүнд 50-д хувь нь интернэтийн саатал гэсэн хариу ирсэн байгаа нь орон нутаг, сумдын хувьд интернэтийн хурд удаан, тасалдал ихтэй байдгийг илтгэж байна. Аудитын явцад сумдаар талбарт ажиллах үед энэхүү асуудал мөн ажиглагдсан.



**Асуулт 3:** “Төрийн сангийн үйл ажиллагааг цахим систем ашиглан орон зай үл хамааран гүйцэтгэх боломжтой юу?” асуултад 100 хувь “Тийм” гэж хариулсан байгаа нь цахим систем өөрийн зорилгоо бүрэн хангасныг илэрхийлж байна.

**Асуулт 4:** “Төрийн сангийн цахим системийн аюулгүй байдал хангагдсан гэж үзэж байна уу?” гэсэн асуултад “Мэдэхгүй” гэж 10 оролцогч хариулсан нь систем хэрэглэгч нар кибер аюулгүй байдал гэж юу болох, хэрхэн өөрийн зүгээс хамгаалах талаар ойлголцогч байгааг илтгэж байна.



**Асуулт 5:** “Төрийн сангийн цахим системийн ашиглалтын хүртээмж, найдвартай байдлыг сайжруулах талаар саналаа товч бичнэ үү.” гэсэн асуумжаар ирсэн саналууд:

*Хүснэгт 4. Асуумжаар ирсэн саналууд/төрийн сангийн мэргэжилтэн/. Системээс шалтгаалсан*

Төрийн сангийн цахим системийн ашиглалтын хүртээмж, найдвартай байдлыг сайжруулах талаар саналаа товч бичнэ үү.	Саналын давтамж
Төрийн албаны цалингийн нэгдсэн системд оны сүүл болон сарын сүүлээр хөгжүүлэлт их хийгддэг. Энэ нь цалин бодоход их ачаалал үүсгэдэг. Хөгжүүлэлтийг үр дүнтэй хийх.	1
Цахимаар хийгдэж байгаа санхүүжилт, орлого хаах зэрэг гүйлгээг хэвлэж архивладаггүй цахимаар архивладаг байх	1
Системийн аюулгүй байдлыг хангах үүднээс дан системээр нэвтрэх, ашиглалтын хүртээмжийг сайжруулах гацалтгүй болгох.	1

Ачаалал ихтэй үед гацалт их үүсдэг.	1
Цахим системийн аюулгүй байдлыг хангах	2
Төлбөрийн хүсэлт болон төсвийн гүйцэтгэлийн мэдээнд залруулга хийх хүсэлтийн баримтыг хэвлэдэггүй сар сараар нь цахим архив үүсгэдэг байх.	1
Нягтлан бодогчид төлбөрийн баримт хэвлэдэггүй байх.	1
Харьяа байгууллагаас сургалт зааварчилгаа муу хангалтгүй байдаг.	1
Төрийн сангийн журмын дагуу ЗЭБ маягт бөглөдөг үүнийг цаасаар хийхийг болих	1


*Хүснэгт 5. Асуумжаар ирсэн саналууд /төрийн сангийн мэргэжилтэн/. Хэрэглэгчээс шалтгаалсан*

Төрийн сангийн цахим системийн ашиглалтын хүртээмж, найдвартай байдлыг сайжруулах талаар саналаа товч бичнэ үү.	Саналын давтамж
Сарын сүүлээр заримдаа ачаалал ихсэн гүйлгээ хянах боломжгүй болох эрсдэл үүсдэг.	1
Интернэтийн хурдыг сайжруулах	2


*Аймаг, сумын төрийн сангийн батлах, хянах мэргэжилтнүүдээс авсан судалгаагаар төрийн сангийн үйл ажиллагааны цахим системүүд хэрэгцээнд бүрэн нийцсэн, орон зайнаас үл хамааран ажлаа гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн, аюулгүй байдлыг хангасан ч хэрэглэгчийн ашиглаж буй интернэтийн саатлаас болж ашиглахад хүндрэл үүсэж байна.*

**Аймаг, 19 сумдын төсөв байгууллагын 120 нягтлан бодогчдоос** “Төрийн сангийн цахим системийн ашиглалтын талаарх” судалгаа авч нэгтгэсэн. Судалгааны дүнг нэгтгэн дүгнэхэд:


**Асуулт 1.** Төрийн сангийн цахим систем таны ажлын хэрэгцээг хэр хангаж байна вэ? гэсэн асуултад 2 хувь буюу 2 оролцогч хангалтгүй гэж хариулсан байна. Бусад 118 оролцогчид хэвийн болон бүрэн хангаж байна гэж хариулсныг үзвэл 98 хувь нь хэрэгцээг хангаж байна гэсэн байна.




**Асуулт 2.** Төрийн сангийн цахим систем ашиглахад ойлгомжтой, хялбар байна уу? гэсэн асуултад 97% буюу 117 оролцогч “тийм”, 3 хувь буюу 3 оролцогч “үгүй” гэж хариулсан байна. Үгүй гэж хариулсан сумын 3 оролцогч “Төрийн сангийн цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ?” гэх асуултад программын тасалдал, интернэтийн саатал, ойлгомжгүй байдал гэж хариулсан байна.



**Асуулт 3.** Системүүд хоорондоо мэдээллээ үнэн зөв, шууд солилцож, уялдаа холбоотой ажиллаж чадаж байна уу? гэсэн асуултад 83 хувь буюу 100 оролцогч тийм, 17 хувь буюу 20 оролцогч үгүй гэж хариулсан байгаа нь төрийн сангийн газар болон бусад холбогдох төрийн байгууллагын системүүд хоорондоо бүрэн мэдээлэл солилцож чадахгүй байгааг илтгэж байна.



**Асуулт 4.** Системд үүссэн асуудлыг систем хариуцагч байгууллагын зүгээс бүрэн, шуурхай шийдвэрлэдэг үү? гэсэн асуулгад 84 оролцогч “тийм”, 31 оролцогч “удаашралтай”, 5 оролцогч “үгүй” гэж хариулсан байна. Удаашралтай гэж хариулсан 31 оролцогчийн 3 оролцогч “Төрийн сангийн цахим систем ашиглахад ойлгомжтой, хялбар байна уу?” гэсэн асуултад “үгүй” гэж хариулсан байгаа нь дээрх 3 хэрэглэгч систем ашиглах явцад бодитой асуудал гарсан гэж үзэхээр байна.



Төрийн сангийн цахим систем хэрэглэгч нягтлан бодогч нарын 98 хувь буюу 118 нь уг систем ажлын хэрэгцээ шаардлага хангаж байна гэж үзэж байгаа ажлын шаардлагаар ашигладаг бусад системтэй холбогдож мэдээллээ солилцдоггүй байдлаас болж ашиглахад хүндрэл бэрхшээлтэй гэж үзэж байна. Энэ нь төрийн сангийн системүүд хоорондоо мэдээллээ бүрэн дамжуулдаг төрийн бусад байгууллагын системүүд, нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн системүүдтэй шууд холбогдож ажил бүрэн хөнгөвчилж, алдаагүй мэдээлэл дамжуулахгүй байгааг илэрхийлж байна.

*Хүснэгт 6. Асуумжаар ирсэн саналууд /нягтлан бодогч/. Системээс шалтгаалсан*

<b>Төрийн сангийн цахим системийн ашиглалт, хүртээмж, найдвартай байдал, бусад системтэй хэрхэн холбогддог, сайжруулах талаар санал байвал товч бичнэ үү.</b>
Аливаа асуудал үүсэхэд хүлээлтгүй шууд холбогдож асууж лавлах зөвлөгөө авах шийдвэрлүүлэх холбогдох утас харилцах хаягтай баймаар байна
Ачаалал ихтэй үед тасалддаг, оны сүүлээр цалингийн программ болон гүйлгээний программууд их гацдаг, тасалддаг. Төрийн сангийн гүйлгээ хянах, батлах хурдан шуурхай байх.
Ажил хөнгөвчилдөг. Ашиглалтын байдал сайн хүртээмж хангалттай. Ойлгомжтой байдаг
Бусад бүх систем хоорондоо уялдаа холбоотой нэг нэгнээсээ хөрвөдөг бол сайн байна.
Бусад системтэй уялдах уялдааг сайжруулах, хэрхэн холбогдож байгаа талаар мэдээлэл өгөх
Гар утас дээр ажиллахад илүү хялбар болгох
Заавар гарын авлага авдаггүй. Сургалт хангалттай өгөх. Шинэчлэлээ сайн мэдээлж байх
Илүү хялбар болгох, мэдээллийн шинэчлэл хурдан болгох
Илүү хялбар болсон, Найдвартай, ойлгомжтой
Нийгмийн даатгалын системрүү хөрвүүлдэг болох, холбогдох шаардлага байна. Цалингийн системээс Нийгмийн даатгалын тайлан илгээдэг болох
Санхүүгийн программтай холбох, уялдаатай байх, бусад э баланс татагдах мөн өмчин программтай холбогдох
Нягтлан бодогчдын dynamic программаас Санхүүгийн тайлангийн шинэ систем болох <a href="https://finperform.mof.gov.mn/">https://finperform.mof.gov.mn/</a> рүү хөрвүүлэлт хийдэг болмоор байна тэгвэл нягтлангуудын ажил бага ч гэсэн хөнгөрнө.
Төрийн сангийн цахим системийн ачаалал ихсэх үед гацах, удаашрах тохиолдол гардаг тул системийн хурд, найдвартай байдлыг анхаарах хэрэгтэй байна. Мөн бусад төрийн байгууллагуудын системтэй (E-Mongolia, Татварын систем) илүү уялдаатай, автомажсан байдлаар холбогддог болбол цаг хугацаа хэмнэхэд тустай байна. Системийн интерфэйсийг илүү ойлгомжтой, хэрэглэхэд хялбар болгож сайжруулах саналтай байна."
Шилэн дансанд хөрвөх, гүйлгээг данс; Шилэн дансны систем рүү мэдээлэл татдаг баймаар байна;

*Хүснэгт 7. Асуумжаар ирсэн саналууд /нягтлан бодогч/. Хэрэглэгчээс шалтгаалсан*

<b>Төрийн сангийн цахим системийн ашиглалт, хүртээмж, найдвартай байдал, бусад системтэй хэрхэн холбогддог, сайжруулах талаар санал байвал товч бичнэ үү.</b>
Нягтлан бодогч ажлын ачаалал маш их байна. мөн маш олон систем ашиглаж байна. Ажиллахад тоног төхөөрөмж хангалттай биш. Интернэтийн хурд, цахилгаан муу.
Одоогоор асуудал үүсээгүй байна

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ



Олон төрлийн системүүдэд нэвтрэх эрхийг нэвтрэлтийн нэгдсэн системд холбож шийдсэн нь сайн шийдэл болсон байна. Хувийн мэдээллээ өгч байгаа төрийн албан хаагчийн хувьд ямар мэдээллүүдийг нь авч байгаа талаар мэдээлэлгүй, системийн зүгээс хэрэглэгчид мэдэгдэхгүй байна.



Системүүдийн хоорондын мэдээлэл солилцох үйл явц хийгдэж байгаа ч хэрэглэгчийн туслах цонх /системд гарсан алдаа, санал гомдлыг авах, нэгтгэх/-ны хөгжүүлэлт удаашралтай байна.

## БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХИЙН ТУЛД ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ТОГТВОРЖУУЛАХ, ТӨРИЙН САНГИЙН БОЛОН ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН БОЛОВСОН ХҮЧНИЙГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ НЭН ЧУХАЛ БАЙНА.

2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт төсвийн хязгаар, орлого бүрдүүлэлтээс хамааран батлагдсан төсөв, төсвийн хуваарийн дагуу олгогдохгүй, шат шатны байгууллагуудад төрийн сангийн үйл ажиллагааны журмын мөрдөлтийг сайжруулах шаардлагатай байна.

2.1.1. Төсвийн санхүүжилтийн эрх олголт нь батлагдсан төсвийн хуваарь, хууль тогтоомж, холбогдох баримт бичгийн шаардлагад нийцэж байгаа ч төсвийн орлого бүрдүүлэлт, хязгаарлалттай холбоотой хугацаандаа олгогдоогүй байна.

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ын 2 дугаар зүйлийн “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох” 2.1-д “Төрийн сан төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг Төсвийн тухай хуулийн 37.1.8-д заасны дагуу төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн олгоно.” гэж заасан. Журмын 2 дугаар зүйлийн 2.6.-д орон нутгийн төсвийн санхүүжилтийн эрхийг Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан дараах байдлаар олгоно гэж заасан. Үүнд:

Зардлын төрөл	Санхүүжилт олгох хугацаа
2.4.1.үндсэн үйл ажиллагааны зардал; 2.4.2.гүйцэтгэлд суурилсан санхүүжилт; 2.4.3.Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөр; 2.4.4.байр ашиглалтын үйлчилгээ; 2.4.5.харуул, хамгаалалтын зардал; 2.4.6.холбооны суваг ашигласны хөлс 2.4.7.тээврийн үйлчилгээ; 2.4.8.халамжийн санхүүжилт; 2.4.9.орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг;	санхүүжилтийг тухайн сарын ажлын <b>эхний 5 өдрийн дотор</b> мөн журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан олгоно; <b>/Улсын (орон нутгийн) төсвийн байгууллагуудад санхүүжилтийн эрх олгох жагсаалт- СЭБ 1 маягт/</b>
2.4.9.орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг; 2.4.13.орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг;	санхүүжилтийг <b>ажлын 2 өдөрт</b> багтаан мөн журмын 24 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан сум, дүүргийн зохих дансанд хуваарилна; <b>/Улсын (орон нутгийн) төсвөөс хуваарилах ..... санхүүжилтийн эрх олгох жагсаалт-СЭБ 2 маягт/</b>
2.4.10.Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгө; 2.4.11.ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг; 2.4.12.татаас санхүүжилт; 2.4.13.орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг; 2.4.14.бусад зориулалт.	журмын 25 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэж, холбогдох шийдвэр, баримт бичиг (гэрээ, гэрээг дүгнэсэн акт, ажлын тайлан, үр дүн, зохих тооцоолол)-ийг төсвийн захирагчаар баталгаажуулан төсвийн байгууллага харьяалах төрийн санд ирүүлнэ <b>/..... хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн эрхийн хүсэлт-СЭБ 3 маягт/</b>

Мөн журмын 2.6.4-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь төсвийн хуваарьт бууруулах өөрчлөлт орсон тухай бүрд санхүүжилтийн тооцоог хийж, энэ журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан төвлөрүүлнэ.” гэж заасан.

Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН БОЛОН ЗАРЦУУЛАЛТЫН ЭРХИЙН ТУХАЙ ЖУРАМ” 4 дүгээр зүйлд санхүүжилтийн эрх нээх зохицуулалтыг мөн тусгасан. /Сангийн сайдын 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 162 дугаар тушаал хүчингүй болсон/

Төсвийн тухай хуулийн 65; 66 дугаар<sup>2</sup> зүйлүүдэд заасны дагуу аймаг, сумын жилийн төсвийн сар, улирлын хуваарийг аймаг, сумын Засаг даргын захирамжаар батлан, мөрдөж байна.

Аймгийн төсвөөс 213401/ Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага/-с 10 төсөвт байгууллагын урсгал үйл ажиллагааны санхүүжилт, орон нутгийн хөрөнгө оруулалт, 1 тусгай сан /Халамжийн сан/, 7 байгууллагын тогтмол зардал, орон нутгийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлдэг. 213402, 123002-с 19 суманд урсгал үйл ажиллагааны болон ОНХС-ийн санхүүжилтийг хуваарилан олгодог.

*Хүснэгт 8. 2023-2025 оны санхүүжилт. /сая.төг/*

Орон нутгийн төсвөөс санхүүжих	2023 он		2024 он		2025 он	
	Батлагдсан санхүүжилт	Олгогдсон санхүүжилт	Батлагдсан санхүүжилт	Олгогдсон санхүүжилт	Батлагдсан санхүүжилт	Олгогдсон санхүүжилт
Байгууллага /урсгал үйл ажиллагааны санхүүжилт/	15,567.61	15,567.61	22,422.49	22,422.49	27,721.71	23,639.51
Сумын санхүүгийн дэмжлэг	13,636.62	13,621.62	18,251.69	18,251.69	18,797.39	17,292.66
ОНХС-с шилжүүлсэн орлого	12,166.37	11,925.27	14,480.77	13,880.10	12,182.24	11,992.22
<b>Нийт дүн</b>	<b>41,370.60</b>	<b>41,114.50</b>	<b>55,154.94</b>	<b>54,554.27</b>	<b>58,701.34</b>	<b>52,924.39</b>

ОНХС-ийн хувьд 2023-2025 онуудад ОНХНС-с санхүүжилт дутуу тавигдсантай холбоотой аймгийн ОНХС-д хуваарилах санхүүжилт дутуу олгогдсон байна.

Харин 2025 оны хувьд Монгол Улсын Ерөнхий Сайдын 12 дугаар сарын 10-ны 2025 оны 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгаврын дагуу төсвийн хязгаар тогтоон томилолт, тээвэр шатахуун, урсгал засварын зардал зэрэгт хязгаарлалт хийсэн байна. Тус албан даалгавар, улсаас олгох санхүүжилт, татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой 2025 онд орон нутгийн байгууллага болон бусдын санхүүжилт батлагдсанаас 9.8 хувиар дутуу олгогджээ.

*Хүснэгт 9. Сумдын санхүүгийн дэмжлэгийг задлан харуулбал /сая.төг/*

№	Сумын нэр	2023 он		2024 он		2025 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баруунбаян-Улаан	696.2	681.2	997.1	997.1	975.0	901.9
2	Бат-Өлзий	857.6	857.6	968.1	968.1	1,085.6	1,010.9
3	Баянгол	804.5	804.5	1,157.0	1,157.0	1,295.0	1,220.9
4	Баян-Өндөр	706.7	706.7	855.2	855.2	954.8	930.3
5	Богд	819.5	819.5	1,102.0	1,102.0	1,128.4	1,049.8
6	Бүрд	738.4	738.4	1,010.3	1,010.3	1,070.8	1,032.8
7	Гучин-Ус	802.8	802.8	1,140.0	1,140.0	1,275.0	1,160.7
8	Есөнзүйл	789.6	789.6	1,084.9	1,084.9	1,110.6	1,014.4
9	Зүүнбаян-Улаан	749.5	749.5	1,089.4	1,089.4	1,202.0	1,170.4
10	Нарийнтээл	598.2	598.2	900.7	900.7	925.1	866.4

<sup>2</sup> 65.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

66.1. Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11	Өлзийт	711.3	711.3	993.2	993.2	1,074.5	981.8
12	Сант	749.4	749.4	962.7	962.7	1,033.6	949.0
13	Тарагт	849.2	849.2	1,122.8	1,122.8	1,178.5	1,081.7
14	Төгрөг	899.6	899.6	1,258.5	1,258.5	1,337.4	1,227.5
15	Уянга	866.2	866.2	932.4	932.4	1,092.4	1,060.0
16	Хайрхандулаан	875.1	875.1	1,212.4	1,212.4	1,289.6	1,218.8
17	Хархорин	396.1	396.1	527.7	527.7	289.9	-
18	Хужирт	726.7	726.7	937.4	937.4	479.3	415.3
<b>Нийт дүн</b>		<b>13,636.6</b>	<b>13,621.6</b>	<b>18,251,687.1</b>	<b>18,251,687.1</b>	<b>18,797.4</b>	<b>17,292.7</b>

Сумдад олгосон санхүүгийн дэмжлэгийн хувьд 2023-2024 онуудад сар, улирлын хуваарийн дагуу харьцангуй тогтвортой олгож байсан бол, 2025 онд 1-6 сард санхүүжилтийг сардаа олгогдож байсан бол 7 сарынх 9 сард, 8 сарынх 10 сард, 9 сарынх 11 сард, 10-11 сарынх 12 сард, 12 сарынх олгогдоогүй гэх байдлаар батлагдсан сарын хуваарь алдагдсан байна.

Журмын 23 дугаар хавсралт-Улсын (орон нутгийн) төсвийн байгууллагуудад санхүүжилтийн эрх олгох жагсаалт- СЭБ 1 маягтын хөтлөлтийн хувьд-зарим байгууллагууд бүрэн хөтөлж хэвшээгүй, санхүүжилтийн хүсэлтийн хугацааг тодорхой тавиагүй байна. /Аймгийн ЗДТГ; Биеийн, тамир спортын газар; Гэр бүл, хүний хөгжлийн төв, зарим сумдын байгууллага/

Журмын 24 дүгээр хавсралт-Улсын (орон нутгийн) төсвөөс хуваарилах ... **санхүүжилтийн эрх олгох жагсаалт- СЭБ 2 маягт**- орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг буюу сумдын санхүүжилт олгох маягтыг хөтлөн хэвшсэн /ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч 2-3 удаа солигдсонтой холбоотой бүрэн баталгаажуулалт хийх тал дээр дутмаг/, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг /2024 онд Сангийн яамны дотоод хяналтаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу хөтлөлт маягтыг бүрэн хөтөлж эхэлсэн/

Журмын 24 дугаар хавсралт ... **хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн эрхийн хүсэлт-СЭБ 3 маягт**- Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилтийн хүсэлтийг бүрэн хөтөлдөггүй.

Санхүүжилтийн эрх олголт нь төсвийн бүрдүүлэлттэй холбоотой журамд заасны дагуу 5 өдрийн дотор олгогддоггүй, эрх олголт, хүсэлтийн маягтуудын хөтлөлтүүдийг сайжруулах шаардлагатай байна.

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор баталсан “ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ын хавсралтаар баталсан 23-25 дугаар маягтыг аймаг, сумдын зарим байгууллагууд бүрэн хөтлөөгүй байна.

### 2.1.2. Аймаг, сумын төсөвт байгууллагуудын төрийн өмчийн барилгын тогтмол зардлын зарцуулах эрхийг эдийн засгийн ангилал болон шаардлагад нийцүүлэн олгож байна.

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ын 2 дугаар зүйлд зарцуулалтын эрх олголтыг дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

- 2.7.3.Төсвийн хуваарь нь нэгдсэн дүнгээр батлагддаг төсвийн байгууллагын зарцуулалтын эрхийг тухайн төрийн сангийн нэгж нь төсвийн батлагдсан хуваарьтайгаа сар бүр тулгаж, хянана;
- 2.7.4.Төв төрийн сан нь гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын зарцуулалтын эрхийг төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн төлөвлөлтийн программд хянаж оруулсан байгууллага тус бүрийн төсвийн хуваарийн задаргааны дагуу төрийн сангийн холбогдох системээр ажлын 3 өдрийн дотор олгоно.

/Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллага нь нэмэлт төсвийн эх үүсвэр болон зарцуулалтын эрхийг урсгал үйл ажиллагааны төсөвтэй нэгтгэн батлуулж, үйл ажиллагааны дансаараа зарцуулна./

Зардлын төрөл	Санхүүжилт олгох хугацаа/маягт	Хавсаргах баримт
2.8.Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох	*Журмын 26 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан шилжүүлнэ. *Цахим системээр дамжаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зохих журмын дагуу эрх нээснээс хойш ажлын 2 хоногийн дотор гүйцэтгэгч байгууллагад болон захиалагчийн холбогдох дансанд тус тус шилжүүлнэ; <b>/ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙН ЖАГСААЛТ-Маягт-ХОС/</b>	
2.9.Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрх олгох	журмын 27 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан зардлын эрхийг төсвийн захирагч буюу захиалагчийн шийдвэр, хууль болон гэрээнд заасан холбогдох заалтыг үндэслэн олгоно; <b>/БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ЭРХ ОЛГОХ ЖАГСААЛТ- Маягт-БХЭ/</b>	гэрээ, комиссын дүгнэлт, ашиглагч байгууллагын тодорхойлолт
2.10.Захиалагчийн хяналтын зардлын эрх олгох	журмын 28 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан олгоно <b>/ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ЗАРДЛЫН ЭРХ ОЛГОХ ЖАГСААЛТ- Маягт- ЗХЭ/</b>	*албан томилолт, тээвэр шатахуун, шуудан холбоо, бичиг хэрэг, багаж хэрэгслийн зардлыг төсөв захирагчийн шийдвэр, батлагдсан төсөв; *гэрээгээр гүйцэтгүүлэх захиалагчийн хяналтын зардлыг төсөв захирагчийн шийдвэр, гэрээ, ажлын тайлан, гэрээ дүгнэсэн актын хамт.
2.11.Норм, нормативын зардлын эрх олгох	журмын 28 дугаар хавсралтад заасан маягтаар баталгаажуулан	холбогдох шийдвэр, баримт бичиг (гэрээ, ажлын тайлан)-ийн хамт
2.12.Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох	журмын 32 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулсан нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлт. /Төрийн сан нь энэ журмын 2.12.2-т заасан шаардлагыг хангасан төсвийн байгууллагын хүсэлтийг хянаж, ажлын 3 өдрийн дотор зарцуулах эрхийг олгоно;/ <b>/НЭМЭЛТ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ЭРХИЙН ХҮСЭЛТ-Маягт-НТ 1/</b>	Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу тухайн эх үүсвэрийг нотлох холбогдох тушаал, шийдвэр, гэрээ; нэмэлт төсвийг зарцуулах тухай төсвийн захирагчийн шийдвэр болон бусад холбогдох шийдвэр; /Орлогын гүйлгээний хуулга/

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраас 2026 онд хийж гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хяналтын тогтолцоо, захиалагчийн хяналтын үр нөлөө” аудитаар Аймгийн ГХБХБГ нь 2023-2025 онд нийт 177,800.0 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын санхүүжилтийг байгууллагын үндсэн дансаар; Аймгийн ЗДТГ нь 2024, 2025 онд нийт 98,878.6 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг “82404-Барилгын техник хяналт”-д зарцуулалтын эрхээ тавиулаагүй, “80101-Үндсэн үйл ажиллагааны зардал” арга хэмжээнээс зарцуулсан зөрчил илэрч зөвлөмж өгсөн.

Хүснэгт 10. Нэмэлт санхүүжилтийн эрх олголтыг 2023-2025 оны байдлаар харуулбал

Сар	Эдийн засгийн ангиллаар эрх олголт /давхардсан тоогоор/		
	2023	2024	2025
1	14	15	13
2	37	55	56
3	88	81	41
4	81	98	88
5	82	156	55
6	85	178	98
7	60	36	68
8	8	6	17
9	22	83	31
10	61	80	34
11	90	86	8

12	209	268	17
<b>Нийт тоо</b>	837	1142	526
<b>Нийт дүн</b>	<b>6,420.6</b>	<b>15,721.1</b>	<b>13,862.1</b>

Нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг журмын дагуу олгосон байна. Харин хавсаргах баримтын хувьд дээд газрын шийдвэр хүлээгдэх зэрэг байдлаас хамааран зарим анхан шатны баримтын бүрдэл дутуу байх тохиолдол байна.

Аймаг, сумын төсөвт байгууллага, төрийн өмчийн барилгын тогтмол зардал, төсөл сангийн төсвийн зарцуулах эрхийг эдийн засгийн ангилал болон шаардлагад нийцүүлэн олгосон бол ОНХС, болон 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал, 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, 81102-Орон нутгийн нөөц хөрөнгө, 81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зэрэг арга хэмжээний зардлуудын санхүүжилтүүд төсвийн хязгаарлалтаас хамааран дутуу олгогдсон байна.

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ын дагуу захиалагчийн хяналтын зардлын эрх олгох, Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрх олгохдоо нэмэлт дансаар дамжуулж, журмын хавсралт маягтуудын дагуу хянан зарцуулах эрхийг олгох шаардлагатай байна.

**2.2. Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагааг сайжруулж, гүйлгээг хянаж буй төрийн сангийн мэргэжилтэн, төсвийг захиран зарцуулж буй удирдлага, нягтлан бодогчдын хариуцлагыг нэмэгдүүлж, чадавхжуулах шаардлагатай байна.**

**2.2.1. Аймаг, сумдын хэмжээнд бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэлтэй тулган баталгаажуулж байгаа боловч хагас жил тутам тогтмол хийдээгүй, Төрийн сангийн баталгаажуулалт хангалтгүй байна.**

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.24-т “Энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан албан тушаалтан бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг мөн журмын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу үйлдэн хагас жил тутам харьяа төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулна” гэж заасан.

Аймгийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 206 төсвийн байгууллагын идэвхтэй 1197 данс, идэвхгүй 202 данс нийт 1399 данс бүртгэлтэй байна. Бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг 2023-2025 онд харьяа Төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулсан байдлыг аймаг, сумаар харуулбал:

Хүснэгт 11. Баталгаажуулсан бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгаа

№	Аймаг, сумын нэр	Төсвийн байгууллагын тоо	Идэвхтэй дансны тоо	Үүнээс: Үндсэн, нэмэлт дансны тоо	2023 он /дансны тоогоор/		2024 он /дансны тоогоор/		2025 он /дансны тоогоор/	
					Эхний хагас жил	Жилийн эцэс	Эхний хагас жил	Жилийн эцэс	Эхний хагас жил	Жилийн эцэс
1	Аймгийн СТСХ	44	176	92		32		59	3	42
2	Арвайхээр	22	90	46	19	17	18	26	20	46
3	Баруунбаян-Улаан	6	48	14		6		6		10
4	Бат-Өлзий	9	53	20		11		13		13
5	Баянгол	6	47	14	4	4	3	4	2	11
6	Баян-Өндөр	6	47	14		14		14		14
7	Богд	8	51	18		16		12		16

8	Бүрд	6	49	14			2		7	
9	Гучин-Ус	6	46	14		12	13		14	
10	Есөнзүйл	6	46	14		11	10		6	
11	Зүүнбаян-Улаан	6	47	14		11	11		7	
12	Нарийнтээл	8	54	18		10	10		11	
13	Өлзийт	6	47	14		3	3		3	
14	Сант	6	47	14		11	11		12	
15	Тарагт	7	50	16		13	2		8	
16	Төгрөг	6	47	14		4	12			
17	Уянга	10	57	22			1	1	1	
18	Хайрхандулаан	6	50	14			3		3	
19	Хархорин	22	90	46			17		22	
20	Хужирт	10	55	22		15	16	22	22	
<b>Нийт дүн</b>		<b>206</b>	<b>1197</b>	<b>454</b>	<b>23</b>	<b>190</b>	<b>38</b>	<b>251</b>	<b>25</b>	<b>268</b>

Эх сурвалж: Аймаг, сумдаас ирүүлсэн Төрийн сангийн бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгаа

Дээрх хүснэгтээс харахад хагас жилийн дансны үлдэгдлийн баталгаажуулалтыг 2023 онд 23, 2024 онд 38, 2025 онд 25 дансанд тус тус хийсэн нь хангалтгүй, харин жилийн эцсийн байдлаар 2023 онд 190, 2024 онд 251, 2025 онд 268 дансанд баталгаажуулалт хийсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Нийт үлдэгдлийн баталгаа ирүүлэх үндсэн болон нэмэлт дансны тоотой харьцуулахад 41.8-59.0 хувийг эзэлж байна. Энэ нь аймаг, сумдын төсөвт байгууллагын нягтлан бодогч нар бүртгэлийн дансны баталгааг тогтмол хийж хэвшээгүй, маягтыг нэг хувь үйлдэж, төрийн санд хувийг үлдээдэггүйтэй холбоотой байна.

Аймаг, Арвайхээр, Баянгол, Уянга, Хужирт сумд хагас жилийн баталгаажуулалтыг тодорхой хэмжээнд хийсэн бол бусад сумдын хувьд хагас жилийн баталгаажуулалтыг огт хийдэггүй байна.

Аудитын тулгалтаар бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааны маягтуудын огноо, албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг зэрэг шаардлагатай мэдээллийг бүрэн тусгаагүй, дутуу бөглөсөн маягтыг хүлээн авсан зөрчил илэрсэн. Түүнчлэн харьяа Төрийн сангийн мэргэжилтэн баталгааны маягтад өөрийн гарын үсэг, огноо, тамга, тэмдгийг бүрэн дарж баталгаажуулаагүй байгаа нь баримтын бүрдэл, хүчин төгөлдөр байдлыг хангахгүй нөхцөл үүсгэж байна.

Зураг 7. Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 5 дугаар хавсралт. Маягт ТТ-5

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 5 дугаар хавсралт  
Маягт ТТ-5

БҮРТГЭЛИЙН ДАНСНЫ ҮЛДЭГДЛИЙН БАТАЛГАА

Мөнх... дугаар бүртгэлийн дансаар тухайн жилийн орлого, зарлагын гүйлгээ, дансны үлдэгдлийг дараах байдлаар баталсан болохыг мэдэгдэж байна.

2023 оны жилийн эцсийн үлдэгдэл	2023 оны улсын төсөв	2023 оны орлого	2024 оны зарлага	2024 оны жилийн эцсийн үлдэгдэл
10,000,000	Санхүүжилт	327,223,400	172,027,447	69,211,271
	Орлого	327,223,400		

Үлдэгдлийн баталгааг баталгаажуулсан:

Төрийн сангийн мэргэжилтэн: \_\_\_\_\_ он сар өдөр

Баталгааны тэмдэг, гарын үсэг: \_\_\_\_\_

Ерөнхий/Ахлах нягтлан бодогч: \_\_\_\_\_

Бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгаа

Мөнх... дугаар бүртгэлийн дансаар тухайн жилийн орлого, зарлагын гүйлгээ, дансны эний, эцсийн үлдэгдлийг дараах байдлаар баталсан болохыг мэдэгдэж байна.

Өөрийн жилийн эцсийн үлдэгдэл	2024 оны улсын төсөв	2024 оны орлого	2024 оны зарлага	2024 оны жилийн эцсийн үлдэгдэл
	Санхүүжилт	80942740	80942700	
	Орлого			

Үлдэгдлийн баталгааг баталгаажуулсан:

Дата: \_\_\_\_\_ Гарын үсэг: \_\_\_\_\_ / Тамга, Нар

Ерөнхий/Ахлах нягтлан бодогч: \_\_\_\_\_

Иймд бүртгэлийн дансны үлдэгдлийг эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тамга тэмдгийг бүрэн дарж баталгаажуулах баримтын бүрдлийг хангаж, хагас болон бүтэн жилээр тогтмол хийж хэвшүүлэх, Төрийн сангийн баталгаажуулалтыг сайжруулах шаардлагатай байна. Хагас, бүтэн жилээр дансны үлдэгдлийн баталгааг бүрэн хөтөлж хэвшсэнээр санхүүгийн тайлан гаргахад мэдээллийн үнэн зөв байдал хангагдахад эерэг нөлөөтэй юм.

Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.11.2-т “Төв төрийн сангийн тухайд энэ журмын 3.11.1-д заасан архивын нэгж нь дараах хэсгээс бүрдэнэ, 3.11.2.1-т “Төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдлийн хураангуй тайлан” гэж заасны дагуу архив, албан хэрэг хөтлөлтийг явуулах шаардлагатай байна.

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аймаг, сумдын бүртгэлийн дансны үлдэгдлийг хагас жил тутам хийж баталгаажуулаагүй, зарим бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгаанд эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тамга тэмдэггүй, бүрэн бус хөтөлсөн маягтыг хүлээн авч, Төрийн сангийн мэргэжилтэн баталгааны маягтад гарын үсэг, огноо, тамга, тэмдгийг бүрэн дарж баталгаажуулаагүй, аймаг, сумдын Төрийн сангийн баталгаажуулалт нь 41.8-59.0 хувь буюу хангалтгүй байна.

### 2.2.2. Төрийн сангийн төлбөр, тооцооны гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан эсэхэд зохих хяналт, баталгаажуулалт хийгээгүй гүйцэтгэсэн нь хяналт сул байгааг харуулж байна.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5-д “Төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих үүрэгтэй” гэж заасны дагуу Төрийн сангийн орлого, зарлагын гүйлгээг цахим хэлбэрээр гүйцэтгэж, төлбөр тооцооны баримтыг төсвийн захирагч, нягтлан бодогч нар цахим гарын үсгээр баталгаажуулж байна. Цахим гарын үсгээр баталгаажуулж байгаатай холбоотой эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэггүй ажил гүйлгээ гарах нөхцөл үүсэхгүй сайн талтай байна.

Мөн цахим системийн эрхийн бүртгэлийг Сангийн яамны [finance.gov.mn](http://finance.gov.mn) нэгдсэн нэвтрэлтийн “Эрхийн бүртгэлийн сангийн систем”-ээр төсөвт байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн баталгаа, цахим төлбөрийн мэдэгдэл, томилогдсон тушаал шийдвэр, нягтлан бодогчийг бүр томилогдож байгаа тохиолдолд Сангийн яам болон аймгийн СТСХ-тэй зөвшилцөх бичгийг үндэслэн эрхийг нээж өгч байна.

Аймгийн хэмжээнд 2023-2025 онд төрийн сангийн цахим системээр давхардсан тоогоор 2023 онд 113,474 ш, 2024 онд 123,275 ш, 2025 онд 118,453 ш зарлагын гүйлгээ хийгдсэн бөгөөд дараах байдлаар хянасан байна. Үүнд:

Хүснэгт 12. Төрийн сангийн цахим системээр 2023-2025 онд хийгдсэн зарлагын гүйлгээ

№	Аймаг, сумын нэр	2023 оны гүйлгээний тоо				2024 оны гүйлгээний тоо				2025 оны гүйлгээний тоо			
		Нийт гүйлгээ	Банк хооронд	Буцаасан	Амжилтгүй гүйлгээ	Нийт гүйлгээ	Банк хооронд	Буцаасан	Амжилтгүй гүйлгээ	Нийт гүйлгээ	Банк хооронд	Буцаасан	Амжилтгүй гүйлгээ
1	Аймгийн СТСХ	29,563	27,617	1,582	364	34,686	33,343	1,041	302	29,667	28251	1026	390
2	Арвайхээр	12,653	11,757	720	176	12,540	12,149	289	102	18,396	17842	313	241
3	Баруунбаян-Улаан	2,836	2,487	239	110	2,903	2,665	152	86	2,601	2430	120	51
4	Бат-Өлзий	3,826	3,340	389	97	4,641	4,084	454	103	4,978	4296	565	117
5	Баянгол	2,788	2,625	103	60	3,076	2,964	37	75	2,908	2800	51	57
6	Баян-Өндөр	3,028	2,738	234	56	3,161	2,890	171	100	2,652	2485	102	65

7	Богд	4,024	3,802	117	105	4,203	3,886	210	107	3,912	3705	130	77
8	Бүрд	2,915	2,798	27	90	3,104	3,007	41	56	2,746	2594	44	108
9	Гучин-Ус	3,318	2,789	366	163	3,237	2,847	331	59	3,007	2622	302	83
10	Есөнзүйл	2,725	2,608	71	46	2,938	2,862	51	25	2,606	2504	71	31
11	Зүүнбаян-Улаан	2,863	2,530	265	68	3,215	2,953	209	53	2,707	2554	120	33
12	Нарийнтээл	4,423	3,995	133	295	3,975	3,709	182	84	3,811	3532	140	139
13	Өлзийт	2,761	2,503	134	124	3,017	2,771	135	111	2,620	2390	136	94
14	Сант	2,953	2,625	230	98	2,827	2,689	71	67	2,715	2494	149	72
15	Тарагт	3,070	2,922	64	84	3,389	3,273	80	36	3,114	2912	74	128
16	Төгрөг	2,951	2,781	122	48	3,165	3,030	45	90	2,941	2828	36	77
17	Уянга	5,557	5,123	78	356	5,727	5,486	78	163	5,428	5179	94	155
18	Хайрхандулаан	2,820	2,549	133	138	3,153	2,994	113	46	2,702	2510	119	73
19	Хархорин	13,553	12,871	416	266	14,942	14,356	340	246	13,599	13248	147	204
20	Хужирт	4,847	4,478	294	75	5,376	5,154	124	98	5,343	5121	130	92
Нийт дүн		113,474	104,938	5,717	2,819	123,275	17,112	4,154	2,009	118,453	112,297	3,869	2,287

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн гүйлгээний жагсаалт

Төсөвт байгууллагаас эрсдэлтэй гүйлгээ гарахаас сэргийлж аймаг, сумын төрийн сангийн мэргэжилтнүүд 2023-2025 онд нийт 355,202 ш гүйлгээний 3.87 хувь буюу 13,740 ш гүйлгээг хууль, журам, зааврын дагуу хянан, буцаасан байна.

Дараах тохиолдолд гүйлгээг буцаасан байна. Үүнд:

- Хяналтын хэсэгт анхан шатны баримт дутуу бүртгэсэн, иж бүрдэл болоогүй.
- Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал буруу
- Дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн харьяа төсвийн байгууллагын үйл ажиллагааны дансыг түр хаалгах хүсэлтийг ирүүлсэн
- Мөнгөн дүн буруу
- Зөвшөөрөгдсөн орлого бууруулах гүйлгээнээс бусад тохиолдолд орлого бууруулсан гүйлгээ
- Төрийн сан, төсвийн байгууллагын харилцааг зохицуулсан журмыг зөрчсөн
- Төлбөрийн хүсэлтийн мөнгөн дүн, үндэслэх анхан шатны баримтын дүнгээс их
- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн
- Төрийн сангийн ажилтан батлахгүй 72 цаг болсон тул цуцлав.
- Төсвийн тухай хуулийн 24.4 дэх заалтыг зөрчсөн /24.4 Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно/
- Төсвийн тухай хуулийн 25.10 дэх заалтыг зөрчсөн /25.10 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно/
- Төсвийн тухай хуулийн 44.3 дэх заалтыг зөрчсөн /44.3.Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно/

Харин дараах тохиолдолд гүйлгээг программаас автоматаар амжилтгүй төлөвт шилжүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн багц хүрэлцэхгүй байна
- Бэлтгэн нийлүүлэгчийн дансны дугаар бүртгэлгүй байна
- Нийлүүлэгч утга хоосон байна
- Үнийн дүн зөрүүтэй байна
- Бэлтгэн нийлүүлэгчийн данс давхар бүртгэгдсэн байна
- Төсвийн сар нээгдээгүй байна
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаартай албан даалгаврын дагуу тус ангилал нь гүйлгээ үүсгэх боломжгүй байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.8-т “Төрийн сан нь сар бүрийн эцсийн ажлын өдөр 14 цагт зарлагын гүйлгээг хаана” гэж заасан бөгөөд аудитаар 2024-2025 оноос түүвэрлэн 4 дүгээр сарын эцсийн ажлын өдрийн гүйлгээг үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт 13 2024-2025 оноос түүвэрлэн 4 дүгээр сарын эцсийн ажлын өдрийн гүйлгээ хийсэн цаг*

Огноо	Банк хооронд илгээсэн		Буцаасан		Амжилтгүй гүйлгээ		Нийт гүйлгээний тоо	Нийт гүйлгээний мөнгөн дүн
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн		
2024 он	4	27.8	12	9.2		-	16	37.0
2025 он	26	279.1	24	23.0		-	50	302.1
<b>Дүн</b>	<b>30</b>	<b>306.9</b>	<b>36</b>	<b>32.2</b>	-	-	<b>66</b>	<b>339.1</b>

Дээрх хүснэгтээс харахад зарлагын гүйлгээ хааснаас хойш төсөвт байгууллагуудын нягтлан бодогч, удирдлагууд төрийн сангийн цахим системээр нийт 339.1 сая төгрөгийн 66 ш гүйлгээг илгээсэн байна. Төрийн сангийн систем нь журмын дагуу дээрх хугацаанд автоматаар хаагдаж гүйлгээг батлах боломжгүй болдог байна.

Аудитын явцад 2023-2025 онд Төрийн сангийн цахим системээр хийгдсэн “Банк хооронд илгээсэн” нийт 334,347 гүйлгээний 1.1 хувийг түүвэрлэн төлбөрийн хүсэлт болон хяналтын хуудасны анхан шатны баримттай тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Хүснэгтээр харуулбал :

*Хүснэгт 14 Зардлын гүйлгээний түүвэр /сая.төг/*

№	Зөрчлийн утга	2023 он		2024 он		2025 он		Нийт гүйлгээний тоо	Нийт мөнгөн дүн
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн		
1	Анхан шатны баримтын бүрдэл дутуу	158	402.2	95	260.6	124	423.00	377	1085.80
2	Тушаал шийдвэр байхгүй	7	30.8	8	90.5	30	24.46	45	145.78
3	Гарын үсэг дутуу	3	1.6	5	3.0	7	16.23	15	20.84
4	Гүйлгээний утга	87	156.9	67	76.6	123	145.81	277	379.33
5	Эдийн засгийн ангилал	12	36.2	19	116.8	20	128.91	51	281.87
6	Буруу баримт хавсаргасан			3	2.2			3	2.25
7	2025-2026 оны баримт хяналтын хуудаст орж ирсэн	112	393.3					112	393.27
<b>Нийт дүн</b>		<b>379</b>	<b>1,021.0</b>	<b>197</b>	<b>549.8</b>	<b>304</b>	<b>738.41</b>	<b>880</b>	<b>2,309.11</b>

Дээрх хүснэгтээс харахад анхан шатны баримтын бүрдэл дутуу, гүйлгээний утга /бараа, материал, төлбөр гэх мэт тодорхой бичдэггүй/, эдийн засгийн ангилалтай холбоотой зөрчил ихээхэн гарсан байна./дэлгэрэнгүй тайлангийн Хавсралт-1/ Мөн 2023 оны цахим төлбөрийн гүйлгээний хяналтын хуудаст 2025-2026 оны өөр байгууллагын орлогын хуулга, тушаал шийдвэр зэрэг анхан шатны баримтууд программын алдаанаас шалтгаалж орж ирж байгаа нь нууцлал алдагдах эрсдэлийг үүсгэж байна.

Аймаг, сумын төрийн сан нь зарлагын гүйлгээг хянан дээр дурдсан тодорхой үндэслэл шалтгаануудаар буцааж тодорхой хэмжээнд хяналтыг хэрэгжүүлж байгаа ч аудитын явцад хийгдсэн түүврийн тулгалтаар түгээмэл алдаа зөрчлүүд гарч байгаа нь гүйлгээний хяналтыг сайжруулах, хяналт хийж буй албан хаагчдыг чадавхжуулан, үнэлж дүгнэн хариуцлагуулах шаардлагатай байгааг харуулж байна.


Аудитын явцад нийт аймаг, сумдын төрийн сангийн нийт 28 албан хаагчдаас Төрийн сангийн үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэн хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлуудын талаар цахим асуулгыг авч, дүнг нэгтгэсэн. Тус асуулгын дүнгээс:

**1. Төрийн сангийн мэргэжилтэн, албаны дарга нар гүйлгээг хянан баталгаажуулахад дараах хүндрэлүүд үүсэж байна. Үүнд:**

- Орон нутгийн байгууллагуудад Сангийн сайдын тушаалын "Төсвийн зарим ангилал шинэчлэл батлах тухайг баримтлан гүйлгээ хийдэг. Харин Боловсролын байгууллага бүх зардлаа Бараа үйлчилгээний зардал болон Хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргадаг нь хянахад хүндрэлтэй байдал үүсгэдэг.
- Боловсролын байгууллагуудын хоол, үдийн цайны тендер 1-3 улирал хүртэл зарладаг боловч аж ахуйн нэгж ордоггүй, түр гэрээгээр гүйлгээ хийгдэг нь төрийн сангаас хяналт тавихад хүндрэлтэй байна.
- Төсөв, санхүүгийн мэдлэг дутмаг дарга нар хуулийн дагуу хянан шаардлага тавихад хүлээж авдаггүй. /Санхүүгийн албаны дарга гэх нэршилтэй боловч гүйцэтгэх албан тушаалтан болохоор шаардлага хүлээн авдаггүй/
- Удирдлагуудын санхүүгийн мэдлэг дутмаг, ажлын байрны тогтвор суурьшилгүй байдал, дээд шатнаас ирж байгаа албан бичиг, үүрэг даалгавар хууль журамтайгаа нийцдэггүй. Жишээ нь: биеийн тамир, уралдаан тэмцээнийг хориглосон боловч сар тутам зохион байгуулагдах тэмцээн уралдааны удирдамж ирдэг.
- Сумын Засаг дарга нарт жилд 1-2 удаа тухайн жилд гарсан алдаа зөрчил, хэрэгжиж байгаа хууль, дүрэм журмаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, аймгийн Засаг даргатай байгуулдаг гэрээнд тодорхой заалтаар оруулах шаардлагатай байна. Үүнээс шалтгаалан Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баримтлахгүй шийдвэр гарах тохиолдол заримдаа гардаг Төрийн сангаас тодорхой хэмжээнд мэдээлэл өгдөг боловч хүлээн зөвшөөрдөггүй.
- Ажилтны хариуцлага, хайнга хандлага, мэдлэг ур чадвар, удирдах ажилтны хяналт сул
- Төлөвлөлт буруу буюу тооцоологдоогүй үйл ажиллагаанаас
- Төсвийн сахилга бат ба санхүүжилтийн хүндрэлтэй асуудлууд, хууль, эрх зүйн орчинтой хүндрэлүүд гардаг
- Оны эцсийн гүйлгээ гарахад гацалт өгөх, оны эцсээр зардал нээх үнэхээр хүндрэлтэй байна.
- Тоног төхөөрөмжийн дутагдал, цахим болсноор компьютероос биш утсаар баталж, хянаж байгаа тохиолдолд анхан шатны баримтыг харахгүй батлах, хянах явдал гарч магадгүй. Байгууллагын дарга нараас ийм алдаа гарч байна.


Дээрх асуулгаас дүгнэн үзэхэд гүйлгээний хяналтын түвшинд гарч буй алдаа, зөрчил нь зөвхөн төрийн сангаас хамаарсан бус санхүүгийн мэдлэг дутмаг дарга нар, хариуцлага сул нягтлан бодогч, санхүүгийн төлөвлөлтийн алдаа, салбар хоорондын хууль журмын уялдаат байдал хангагдахгүй байгаагаас мөн хамаарч байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны хараат бус байдал бүрэн хангагдаж байна уу.  
28 responses



Төрийн сангийн үйл ажиллагааны хараат бус байдалд аймаг, сумын удирдлага болон бусад удирдах түвшний албан тушаалтнуудын зүгээс нөлөөлөл үзүүлж байгаа эсэх.

28 responses



Дээрх 2 асуулгын дүнгээс төрийн сангийн үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэн хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээнд удирдлагын зүгээс нөлөөлөл байгааг харуулж байна.

### АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нийт гүйлгээний 1.1 хувийг түүвэрлэн үзэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу, тушаал шийдвэр байхгүй, гарын үсэг дутуу, гүйлгээний утга тодорхойгүй, эдийн засгийн ангилал зөрүүтэй /зориулалт бус/, буруу баримт хавсаргасан, 2025-2026 оны баримт хяналтын хуудаст орж ирсэн зэрэгтэй холбоотой 2,309.11 сая төгрөгийн 880 зөрчилтэй гүйлгээ байна. /ТАБ-ын санхүүгийн тайлангийн аудитаар тус зөрчилтэй гүйлгээнүүдийн эрсдэлд хамрагдсан байдлаар нь зохих шийдвэрүүдийг өгч ажилласан/

### 2.2.3. Аймагын СТСХ болон ихэнх сумд бүртгэлийн дансны тодорхойгүй орлого, буцаалтыг журмын дагуу дансанд байршуулж, холбогдох баримтыг үндэслэн гүйлгээг залруулан буцаалтыг хийж байгаа бол зарим сумд 140020 ангиллаас орлого бууруулан гүйлгээ хийсэн байна.

Төрийн сангийн цахим системээр 2023-2025 онд зарим сумдын бүртгэлийн дансанд орсон тодорхойгүй орлого болон анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй шалтгаанаар буцсан гүйлгээ нь дараах үзүүлэлттэй байна.

Хүснэгт 15. Төрийн сангийн цахим системээр 2023-2025 онд 140020 ангилалд орсон орлого /сая.төг/

Огноо	Нийт		Банк хооронд илгээсэн		Буцаасан		Амжилтгүй гүйлгээ	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2023 он	54	93.5	15	20.0	39	73.5		
2024 он	17	506.0	4	27.8	13	478.3		
2025 он	14	50.2	5	43.6	7	4.9	2	1.7
Нийт дүн	85	649.8	24	91.4	59	556.6	2	1.7

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн гүйлгээний жагсаалт

Тодорхойгүй орлогын дүн 2023 онд 93.5 сая төгрөг байсан бол 2024 онд 506.0 сая төгрөг болж огцом өссөн харагдаж байгаа хэдий ч гүйлгээний тооны хувьд буурсан үзүүлэлттэй байна.

Хархорин, Уянга, Төгрөг, Өлзийт, Тарагт, Сант, Есөнзүйл, Бат-Өлзий, Гучин-Ус сумд 2023-2025 онуудад төрийн сангийн данснаас нэр данс зөрүү гүйлгээ хийхдээ 140020 ангиллаас гарган 91.4 сая төгрөгийг орлого бууруулан гүйлгээ хийсэн байна.

Төрийн сангийн удирдлагын цахим системд шилжсэнээр аймаг, сумдын төрийн сан бүртгэлийн дансны төлбөрийн залруулгын гүйлгээг хийхдээ “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4-т “Төрийн сан бүртгэлийн дансны төлбөрийн залруулгыг энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан маягыг үйлдэн гүйцэтгэнэ” гэж заасны дагуу мемориалын баримт үйлдэн гүйцэтгэж байна.

### 2.2.4. Төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг тусган холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, тайлагнаж байгаа хэдий ч төсөвт

**байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, өглөг авлагын мэдээ баталгаажуулалтыг цаглаварт хугацаанд ирүүлэх талаар харьяа төсвийн байгууллагын нягтлан бодогч нарт заавар зөвлөгөө өгч ажиллах шаардлагатай байна.**

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.6.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хоорондын тооцоог тулган баталгаажуулж, албажуулан эхний хагас жилийн тайланг 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 05-ний өдрийн дотор төв төрийн санд хүргүүлнэ” гэж заасан.

Аймгийн СТСХ нь аймгийн төсвийн байгууллагууд болон сумдын санхүүгийн албанаас нэгтгэсэн урсгал санхүүжилтээс буцаан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг улсын төсвийн орлогод тооцох, нэр данс зөрүү, өглөгт тооцож төвлөрүүлсэн, санхүүжилтээс хасагдах дүн, өөрийн орлогоос болон улсын төсвийн орлогод төвлөрүүлсэн бусад орлогоор ангилан, батлагдсан төсвийн хүрээнд төсвөөс авсан санхүүжилт, буцаан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, төсөв хоорондын тайланг гарган журамд заасан цаглаварт хугацаанд Сангийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т “Аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасны дагуу хуулийн 8.9.1<sup>3</sup>, 8.9.2<sup>4</sup>, 8.9.3<sup>5</sup>-д заасны дагуу төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдын тайлан, аймгийн нэгдсэн тайланд хуулийн хугацаанд нэгтгэгдсэн байна.

Аймгийн СТСХ нь батлагдсан төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг тусган Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд гарган, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраар жил бүр аудитын дүгнэлт гаргуулан ажиллаж байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023–2025 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитыг хуулийн дагуу тогтоосон хугацаанд бүрэн хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитаар нийт 6 зөвлөмж өгөгдсөн. Үүнд:

#### 2023 онд:

- Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацааны дотор зохион байгуулах, заасан хугацаанд зохион байгуулж дуусаагүй бол төсвийн хэмнэлтэд тооцож зарцуулахгүй байх
- Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт хөтөлбөрийг төлөвлөхдөө хэрэгжихүйц байдлаар төлөвлөж, худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах

#### 2024 онд:

<sup>3</sup> төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;

<sup>4</sup> төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх

<sup>5</sup>сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сан нь тухайн шатны төсвийн хагас жилийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны дотор дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх

- Харьяа байгууллага, сумдын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон арга хэмжээний үзүүлэлтийг төсөвт тодотгол хийх бүрд өөрчлөн баталж байх
- Төсвийн нэмэлт санхүүжилтийн эрхийг олгохдоо тушаал, шийдвэрийг үндэслэн санхүүжилтийн эрх олгож байх

**2025 онд:**

- Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон харьяа байгууллагуудын Шилэн дансны цахим сайтад мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн, үнэн зөв, тасралтгүй байршуулж хэвших, илэрсэн зөрчлийг бууруулах зорилгоор дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулж ажиллах
- Худалдан авах ажиллагааг цаг хугацаанд нь төлөвлөн, тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, төлөвлөсөн төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Аудитаар өгсөн зөвлөмжийн 2023, 2024 оны биелэлтийг тооцож, холбогдох арга хэмжээг авч ажилласан бөгөөд 2025 оны аудитын зөвлөмжийн биелэлтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн 2023-2024 оны тайланг Сангийн яамны Э-Тайлан цахим системээр, 2025 оноос “Finperform” цахим системээр тайланг нэгтгэн гаргаж байна.

Аймгийн ИТХ нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3-т “Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах”, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9-д “Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах” гэж заасны дагуу төсвийн гүйцэтгэлийг баталдаг.

Аймгийн ИТХ нь аймгийн 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 27/02, 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 07/06, 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 16/03 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.

*Хүснэгт 16 Аймгийн төсвийн гүйцэтгэл 2023-2025 он*

<b>Огноо</b>	<b>Орлогын гүйцэтгэл</b>	<b>Зарлагын гүйцэтгэл</b>
2023 он	69,076.3	65,546.6
2024 он	94,441.0	86,429.8
2025 он	92,883.6	92,421.1

*Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол /сая.төг/*

Төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээг хүргүүлэх цаглаварт хугацааг дараах хууль, журмаар баталсан байна. Үүнд:


- Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 "Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.", 8 дугаар зүйлийн 8.8.1-т “Төсвийн шууд захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх”,
- Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.7.1-т “Орон нутгийн төсвийн байгууллага төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг төсвийн тухай хуулийн 8.8.1-д заасны дагуу харьяалагдах төсвийн захирагчид хүргүүлнэ гэж заажээ.

Сангийн яамнаас 2024 онд дотоод хяналтыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн 2023, 2024 оны үйл ажиллагаанд хийж гүйцэтгэсэн байна. Тус хяналтаар “Аймгийн СТСХ нь 2024 оны 45 төсөвт байгууллагын 1-12 сарын төвийн гүйцэтгэлийн мэдээ давхардсан тоогоор 540 төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс 532 гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаанд нь хүлээн авч, тулган баталгаажуулсан. Нягтлан бодогч нарт алдаатай мэдээг залруулах талаар аргагүйн зөвлөгөөг өгч ажилласан. Мэдээний ирц 98.5 хувьтай байна гэж дүгнэжээ.

Аудитын түүвэрт аймгийн СТСХ, Арвайхээр, Бат-Өлзий, Өлзийт, Баян-Өндөр, Зүүнбаян-Улаан, Уянга, Сант, Төгрөг сумдын 2023-2025 оны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ хамрагдсан. Үүнээс **төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг** тогтмол хянан баталгаажуулж хэвшсэн - аймгийн СТСХ, Арвайхээр, Бат-Өлзий, Баян-Өндөр, Зүүнбаян-Улаан, Өлзийт сумд; **өглөг, авлагын сарын мэдээ, тайланг** төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээний хамт тогтмол авч баталгаажуулсан- Арвайхээр, Бат-Өлзий, Баян-Өндөр сум байна.

Аудитаар зарим сумдад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг Төрийн сангийн мэргэжилтэн хүлээн авсан огноог тухай бүр тэмдэглэн баталгаажуулдаггүй. /Үүнээс шалтгаалан мэдээг хугацаанд нь ирүүлсэн эсэхийг тодорхойлох боломжгүй/;
- Гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй хүчин төгөлдөр бус төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хянан баталгаажуулсан;
- Өглөг авлагын сарын мэдээ тайланг сар бүр тогтмол авдаггүй;
- Сант сум 2025 оны сарын мэдээг архивласан баримт материал огт байхгүй байна.
- Төгрөг сумын Төрийн сангийн мэргэжилтэн 2025 оны 12 сард тэтгэвэрт гарч, татварын байцаагч хавсран ажиллаж байгаатай холбоотой тухайн сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг огт аваагүй байна.



Мөн эдгээр зөрчлүүдэд зарим төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын хариуцлагагүй байдлаас шалтгаалан гарын үсэг дутуу, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, хугацаа хоцрох, төсвийн гүйцэтгэлийн мэдээг өглөг авлагын мэдээ тайлантай хамт ирүүлэхгүй байх тохиолдол нөлөөлж байна.

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн болон өглөг, авлагын сарын мэдээ тайланг эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тамга тэмдэггүй, бүрэн бус маягыг хүлээн авч, Төрийн сангийн мэргэжилтэн нь гарын үсэг, огноо, тамга, тэмдгийг бүрэн дарж баталгаажуулаагүй, зарим сумд архивд хүлээлгэн өгөөгүй байна.

**2.3. Төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж буй дотоод болон хөндлөнгийн хяналтууд нь үр нөлөөгөө өгч байгаа хэдий ч өгсөн шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилт, биелэлтийг дүгнэж, үр дүнг сайжруулах шаардлагатай байна.**

**2.3.1. Төрийн сангийн төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус дотоод хяналтыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу тогтмол хэрэгжүүлж ажилласан боловч сумдад өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, биелэлтийн үр дүнг үнэлж дүгнээгүй байна.**

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.2-т **төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналт** нь бусад хяналтын байгууллагын чиг үүрэгтэй давхардахгүй байх, мөн эрсдэлд суурилсан зарчмыг баримтлах талаар зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, дотоод хяналт нь аудит, санхүүгийн хяналт шалгалт зэрэг байгууллагын бүрэн эрхийг давхар хэрэгжүүлэх бус, төрийн сангийн үйл ажиллагаанд үүсэж болзошгүй алдаа, зөрчил, санхүүгийн эрсдэлийг урьдчилан илрүүлэх, бууруулах, таслан сэргийлэхэд чиглэнэ.

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6-д аймгийн төрийн сан нь сумын төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг хэрэгжүүлнэ гэж заасан. Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ыг баталсан ба 2024 оны 254 дүгээр тушаалаар 2025 он 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шинэчлэн баталсан.

Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-д дотоод хяналтыг хэрэгжүүлэгч албан тушаалтан нь **хараат бус байдлаар** ажиллана гэж заасан. Тус журмын 6 дугаар зүйлийн 6.1-д **“Дотоод хяналт нь төсвийн хуваарь, төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, төлбөр тооцоог гүйцэтгэх үйл явц нь хууль, журам, зааврын хүрээнд хэрэгжиж буй эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд чиглэгдэнэ”** гэж заасан бөгөөд мөн журмын 6.2-д дотоод хяналтын хийгдэх чиглэлийг 17 заалтаар нарын тусгасан байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:		
Төлөвлөгөөт	Төлөвлөгөөт бус	Өдөр тутмын
Батлагдсан төлөвлөгөөний дагуу тухайн төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.	Иргэд болон төрийн үйлчилгээг хүртэгч аливаа этгээдээс төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол, эрх бүхий хууль, хяналтын байгууллагаас ирүүлсэн саналыг хүлээн авч, шаардлагатай гэж үзвэл удирдлагын саналыг үндэслэн тухайн төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.	Дотоод хяналт хийх эрх бүхий албан эрх бүхий албан тушаалтан төрийн сангийн системүүдээр дамжуулан төрийн сангийн үйл ажиллагаанд түүврийн аргаар дотоод хяналт хийх.

**Төлөвлөгөөт дотоод хяналт хийх** төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар, удирдамжийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар тухайн оны эхний улиралд багтаан батлуулан мөрдөж ажиллана гэж Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын 4 дүгээр зүйлийн 4.2.-д заасан. Сумдаас ирүүлсэн эрсдэлийн үнэлгээг нэгтгэн эрсдэлийн зураглал гарган эрсдэлд суурилсан төлөвлөгөөт дотоод хяналтыг Өвөрхангай аймгийн хэмжээнд 2023-2025 онуудад дараах байдлаар хийж, зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 17 Дотоод хяналт 2023-2025

№	Он	Төлөвлөгөө	Удирдамж	Хяналт хийх сарчилсан төлөвлөгөө	Сангийн яаманд хүргүүлсэн огноо	Дотоод хяналтаар өгсөн зөвлөмж
1	2023	Өвөрхангай аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/22	Аймгийн ЗДТГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр	1.Баян-Өндөр - 3 сар 2.Бүрд - 3 сар 3.Өлзийт – 3 сар 4.Богд- 8 сар 5.Нарийнтээл – 8 сар	2024.01.10-ны өдрийн 01/10 дугаар албан бичиг	Эрхийн бүртгэлийн системийн тохиргоо, хувийн хэргийн бүрдэл, сарын мэдээний иж бүрэн байдал /өр, авлагын өөрчлөлтийг тухай бүр оруулах/, баримтын эмх цэгц, мөрдөж буй хууль эрх зүйн актаар сан үүсгэх,

		дугаар захирамж				мемориал ордер бичиж нябо журналд хавсаргах, журмын дагуу архивлалт хийх, архивын тасагт жил бүр хүлээлгэж өгөх, нэвтрэх эрхээ түр шилжүүлэх үед аймгийн төрийн санд албан бичгээр мэдэгдэх, цахим сургалтын гарын авлагыг өдөр тутамдаа байнга үзэж хэвших талаар <b>9 зөвлөмж</b>
2	2024	Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/30 дугаар захирамж	Аймгийн СТСХ-ийн даргын 2024 оны 04 дугаар сарын 03-ны өдөр	1. Баруунбаян-Улаан - 4 сар 2. Гучин-Ус - 4 сар 3. Богд – 4 сар 4. Нарийнтээл - 5 сар 5. Төгрөг – 5 сар 6. Уянга – 5 сар 7. Хархорин – 5 сар	2025.01.22-ны өдрийн 3-4/38 дугаар албан бичиг	Төрийн сангийн шинэчилсэн журмыг хэрэгжилтийг ханган ажиллах, эрхийн бүртгэлийн системийн бүртгэл хөтлөлт, ТСУЦС-ийн нэхэмжлэх модулийг оновчтой зөв хэрэглэх, цахим нэхэмжлэх хүлээн авах, буцаах, цахим архивын бүрдүүлэлт, нэмэлт санхүүжилтийн дансны эрх олгоход бүрдүүлэх материал, төсвийн гүйцэтгэлийн мэдээний иж бүрэн байдал, зөвшөөрөгдөөгүй ангиллаас орлогын гүйлгээ хийхгүй байхад хяналт тавьж ажиллах <b>9 зөвлөмж</b>
3	2025	Журамд заасны дагуу сарчилсан хуваарь төлөвлөгөөг засаг даргаар батлуулсан	Аймгийн СТСХ-ийн даргын 2024 оны 05 дугаар сарын 19-ний өдөр	1. Баруунбаян-Улаан - 5 сар 2. Баянгол – 5 сар 3. Гучин-Ус – 5 сар 4. Хайрхандулаан – 5 сар 5. Хархорин – 5 сар	2026.01.21-ны өдрийн 3-4/35 дугаар албан бичиг	Төрийн сангийн удирдлагын цахим системээр хийгдсэн гүйлгээний хяналт сайжруулах, орлого бууруулж хийх гүйлгээнд орлогын хуулгыг хавсаргах, төсөв байгууллагын хувийн хэргийн бүрдэл, нэмэлт санхүүжилтийн эрх олгоход бүрдүүлэх материал, эрхийн бүртгэлийн системийн бүртгэл, хөтлөлтийн алдааг засах, төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчдод тавигдах шалгуурыг холбогдох журмын дагуу томилгоо хийх зэрэг <b>7 зөвлөмж</b>

Дээрх хүснэгтээс харахад жил бүр төлөвлөгөөний дагуу сумдад дотоод хяналтыг биетээр болон цахим хослуулан хийж төсвийн ерөнхий нягтлан бодогч, төсөв төрийн сангийн мэргэжилтнүүд, бүх төсөвт байгууллагуудын нягтлан бодогч, эд хариуцагч нарт заавар зөвлөмж өгч, дүнг сангийн яаманд хүргүүлсэн байна.

**Дотоод хяналтын дүгнэлт-** “Зарим сумд сумдын төсвийн ерөнхий нягтлан бодогч болон төрийн сангийн мэргэжилтний ажил үүргийг хавсран хийж байна. Ингэснээр ажлын ачаалал их, хяналт суларч байна. Сумын төсвийн ерөнхий нягтлан бодогчийн зарим нэмэлт ажлыг төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод ажлын ачаалал тэнцвэртэй болно.” гэж дүгнэлтэд дурдсан байна.

**Төлөвлөгөөт бус дотоод хяналтыг** шаардлагатай тохиолдолд зорилтот төрийн сангийн үйл ажиллагаанд хийх бөгөөд төлөвлөгөөг аймаг, нийслэлийн төрийн сан нь Засаг даргын шийдвэрээр батлуулан баг томилон ажиллуулна / Төлөвлөгөөт бус дотоод хяналт хийх шаардлагагүй гэж үзвэл мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана./ гэж Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын 4 дүгээр зүйлийн 4.3.-д заасны дагуу 2024 онд 19 суманд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.9.10.-д “Дотоод хяналтаар илэрсэн зөрчил, эрсдэлийг бууруулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйн улмаас дараагийн шалгалтаар дахин давтагдсан тохиолдолд тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг хүргүүлнэ.” гэж заасан.

Жил бүр дотоод хяналтаар сумдад зөвлөмжүүд тогтмол өгөгдөөд явж байгаа ч, зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнаагүй байна. Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулахын

тулд сумдад зөвлөмжийг хугацаатай өгөх, зөвлөмжийг биелүүлэх төлөвлөгөө, тайланг тогтмол гаргуулах нь зүйтэй юм.

**АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Сумдад дотоод хяналт хийгдсэн боловч Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврын дагуу өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнаагүй, үр дүнг үнэлэх боломжгүй байна.

**2.3.2. Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг зааврын дагуу үнэлж, өдөр тутмын дотоод хяналтыг бүх шатны төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажилласан боловч түүний үр нөлөө, хэрэгжилтийг цаашид сайжруулах шаардлагатай байна.**

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.9.8.-д “Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан албан тушаалтан жил бүрийн эхэнд төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлэх зааварт заасны дагуу үнэлж, удирдлагадаа танилцуулна,” гэж заасан.

Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг дараах аргачлалын дагуу үнэлж, удирдлагад танилцуулна. Үүнд:

2023, 2024 онуудад мөрдөн ажилласан Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”	2025 онд мөрдөн ажилласан Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”
<p>5.1.1. Тухайн төрийн сангийн эрсдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч, төв төрийн сан, аймаг, нийслэлд төрийн сангийн дотоод хяналт хариуцсан эрх бүхий албан тушаалтан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн гүйлгээ баталгаажуулалт хариуцсан мэргэжилтэн, суманд төрийн сангийн төлөөлөгч, дүүрэгт дүүргийн санхүү, төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч нар хавсралт 1, хавсралт 2, хавсралт 4, хавсралт 5-д тус тус заасан маягт, зааврын дагуу үнэлж, эрсдлийн түвшинг тодорхойлно.</p> <p>5.1.2. Төрийн сан харилцагч төсвийн байгууллагын нягтлан бодогч нарын 50-аас доошгүй хувийг хамруулан хавсралт 3-т заасан маягтын дагуу санал асуулгыг авч, нэгдсэн дүнг дотоод хяналтын тайланд тусгана.</p> <p>5.1.3. Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан эрх бүхий албан тушаалтан төрийн сангийн нэгжийн эрсдлийн түвшний зураглал /хавсралт 4/-д 3 болон түүнээс дээш оноотой хэсэгт байрласан тохиолдолд дотоод хяналтанд зайлшгүй хамруулна.</p> <p>5.1.4. Төрийн сангийн нэгж эрсдлийн түвшний зураглал /хавсралт 4/-д 3 болон түүнээс дээш оноотой хэсэгт байрласан эрсдлийг удирдан, бууруулах арга хэмжээ авч ажиллана.</p> <p>5.1.5. Төрийн сангийн нэгжийн эрсдэлийн нэгдсэн үнэлгээ /хавсралт 5/-ний нийт оноо 41 буюу түүнээс дээш бол “өндөр”, 21-40 бол “дунд”, 20 буюу түүнээс бага бол “бага” эрсдэлтэйд тооцно.</p> <p>5.1.6. Үнэлгээний маягтуудыг удирдлагаас хараат бус байдлаар үнэн зөв үнэлж журмын 5.3-т заасны дагуу холбогдох төрийн санд хүргүүлнэ.</p> <p>5.1.7. Дотоод хяналт хариуцсан эрх бүхий албан тушаалтан журмын 2.1.1-д заасан дотоод хяналтын хүрээнд эрсдэлийн нэгдсэн үнэлгээ /хавсралт 5/-г нэгтгэнэ.</p> <p>5.3. Төрийн сангийн үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг журмын 5.1-д заасны дагуу үнэлэн сум, дүүргийн төрийн сан аймаг, нийслэлийн төрийн санд дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор, аймаг нийслэл, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сан Төв төрийн санд дараа оны 2 дугаар сарын 01-ны дотор цахимаар болон албан бичгээр хүргүүлнэ.</p>	<p>5.1.1. Сум, дүүргийн төрийн сан нь энэ зааврын хавсралт 1, 2, 4-6-д заасны дагуу өөрийн төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг хийж, энэ зааврын хавсралт 3-т заасны дагуу эрсдэлийн түвшнийг нэгдсэн хүснэгтэд бөглөн, энэ зааврын хавсралт 10-т заасны дагуу эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн тайлангийн хамт дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн төрийн санд хүргүүлнэ.</p> <p>5.1.2. Төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж нь энэ зааврын хавсралт 1, 2, 4-6-д заасны дагуу өөрийн төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг хийж, энэ зааврын хавсралт 3-т заасны дагуу эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн тайлангийн хамт дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор төв төрийн санд хүргүүлнэ.</p> <p>5.1.3. Аймаг, нийслэлийн төрийн сангийн дотоод хяналт хариуцсан эрх бүхий албан тушаалтан нь энэ зааврын хавсралт 1, 2, 4-6-д заасны дагуу өөрийн төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг хийж, харьяа төрийн сангаас ирүүлсэн эрсдэлийн үнэлгээг нягталж, энэ зааврын хавсралт 3-т заасны дагуу эрсдэлийн түвшнийг нэгдсэн хүснэгтэд нэгтгэж, энэ зааврын хавсралт 10-т заасны дагуу эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн тайлангийн хамт дараа оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор төв төрийн санд хүргүүлнэ.</p> <p>5.1.4. Эрсдэлийн түвшнийг их буюу 15-25 оноотой эрсдэл, дунд буюу 8-12 оноотой эрсдэл, бага буюу 1-6 оноогоор тодорхойлно.</p>

Дотоод хяналтын журмын 5 дугаар зүйлд төрийн сангийн албан хаагч нь эрсдэлийг үнэлэхдээ удирдлагаас хараат бус байдлаар үнэн зөв үнэлнэ. Удирдлагын зүгээс үнэлгээ хийж байгаа албан хаагчид нөлөөлөх, нөлөөлөхийг оролдохыг хориглоно гэж заасан.

“ИХ” эрсдэл	5-с дээш байвал дотоод хяналт хэрэгжүүлэх ба их эрсдэл нь 5-с доош бол эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах, авсан арга хэмжээний биелэлтийг төв төрийн санд тайлагнах, шаардлагатай гэж үзвэл дотоод хяналтыг хэрэгжүүлэх.
“ДУНД” эрсдэл	Эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, авсан арга хэмжээний биелэлтийг төв төрийн санд тайлагнах, шаардлагатай гэж үзвэл дотоод хяналтыг хэрэгжүүлэх.
“БАГА” эрсдэл	Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх ба эрсдэл багатай тул эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн тайланг хүргүүлэх шаардлагагүй.

2023 онд – Нэгтгэлээр аймгийн төрийн сан, 19 сум эрсдэлийн үнэлгээ 3-20 хооронд, аймгийн нийт дундаж эрсдэл 12.2 буюу БАГА үнэлэгдсэн.	2024 онд- Нэгтгэлээр Аймгийн төрийн сан, 6 сум эрсдэлийн үнэлгээ 2-22 хооронд, аймгийн нийт дундаж эрсдэл БАГА үнэлэгдсэн.	2025 онд- Нэгтгэлээр аймгийн төрийн сан, 12 сум эрсдэлийн үнэлгээ 4-12 хооронд, аймгийн нийт дундаж эрсдэл БАГА үнэлэгдсэн.
--	--	---

Дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн сумдын үнэлгээг дахин үнэлж 2023 онд аймаг болон 19 сум, 2024 онд аймаг болон 6 сум, 2025 онд аймаг болон 13 сумын эрсдэлийг нэгтгэн баталгаажуулж Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн байна.

Аймаг, сумдын Төрийн сан нь Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-ын дагуу эрсдэлийн үнэлгээг хийж, тайлагнаж байгаа боловч журмын хавсралт маягт “Төрийн сангийн үйл ажиллагааны талаар харьяа төсвийн байгууллагаас авах санал асуулгын хуудас”, “Төрийн сангийн үйл ажиллагаанд учирсан эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн тайлан”-г бүрэн гаргаж хэвшээгүй байна.

**Өдөр тутмын дотоод хяналтыг** аймгийн төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь харьяа төрийн сангаас түүвэр байдлаар сонгон авч, хяналтын дэлгэцээс эрсдэлтэй гүйлгээнүүдэд анхаарал хандуулж, эрсдэлээс сэргийлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч энэ тухайгаа тухайн жилийн дотоод хяналтын тайланд тусгаж ажиллана гэж Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын 4 дүгээр зүйлийн 4.4.-д заасан. Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.9.7-д “Энэ журмын 3.9.3.3-т заасан дотоод хяналтыг бүх шатны төрийн сан үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлнэ,” гэж заасан байна.

Аймгийн төрийн сангаас 2023-2025 онд сумдын төрийн сангуудад түүвэр байдлаар цахим хяналтыг хэрэгжүүлж алдааг залруулан, зөвлөгөө өгч ажилласан байна.

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Сумдын Төрийн сан нь Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-ын хавсралт маягт “Төрийн сангийн үйл ажиллагааны талаар харьяа төсвийн байгууллагаас авах санал асуулгын хуудас”-г бүрэн гаргаж хэвшээгүй байна.

### 2.3.3. Хөндлөнгийн хяналт нь зөрчлийг бууруулахад тодорхой үр дүнгээ өгч байгаа боловч сумдын түвшинд давтагдан илэрдэг зөрчлүүд арилахгүй байна.

Төрийн аудитын газраас 2014 онд “Төрийн сангийн тогтолцооны 2013 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитыг хийж гүйцэтгэсэн. Тус аудитаар “Өвөрхангай аймгийн Төрийн сангийн салбар, нэгжүүдийн үйл ажиллагаа үр дүнтэй байна.” гэсэн дүгнэлт гарч 4 зөвлөмж, 172.8 сая төгрөгийн 1 албан шаардлага өгсөн ба зөвлөмж, албан шаардлага бүрэн биелсэн байна.

Төрийн аудитын байгууллага нь жил бүр Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д “шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;” заасан бүрэн эрхийн

хүрээнд, 8 дугаар зүйлийн 8.1-д “Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ” гэж заасны дагуу батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу санхүүгийн тайлангийн аудит хийгддэг. Санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн болон нийцлийн 2 төрлийн зөрчлийг илрүүлж дүгнэлт, зөвлөмж, албан шаардлага хүргүүлж байна.

ТАБ-аас 2023-2025 онд илэрсэн нийт санхүүгийн зөрчлийг графикаар харуулбал:

*Хүснэгт 18 ТАБ-ын санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн дүн /сая.төг/*

Он	Зөрчлийн тоо	Зөрчлийн дүн
2023	427	9,443.48
2024	349	31,473.27
2025	412	11,236.58

Дээрх хүснэгтээс харахад 2024 онд санхүүгийн зөрчил 2023 онтой харьцуулахад ихээхэн өсөлттэй байсан бол 2025 онд буурсан үзүүлэлттэй байна.

Нийт зөрчлийн дүнгээс төрлөөр нь ангилан, нийтлэг илэрдэг зөрчлүүдийг дараах хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт 19 ТАБ-ын санхүүгийн тайлангийн аудитын зөрчил төрлөөр /мян.төг/*

Зөрчлийн төрөл	Зөрчлийн ангилал	2023 оны зөрчил		2024 оны зөрчил		2025 оны зөрчил	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөвлөмж	3.Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой	45	51,359.9	10	1,201.4	17	51,698.4
Албан шаардлага	4.2.1.1. Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй	58	1,127,697.9	62	692,634.4	44	11,947.6
	4.2.1.6 Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	33	207,014.1	80	477,704.13	25	75,882.57
	4.2.1.8 Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	12	222,478.7	26	1,055,557.2	9	21,987.2
Төлбөрийн акт	4.2.3.5 Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон	18	28,530.16	2	1,341.5	7	18,792.4
	4. Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй	13	36,531.1	12	5,232.53		
	5. Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн	15	11,726.4	2	10,954.9		
<b>Нийт дүн</b>		<b>194</b>	<b>1,685,338.2</b>	<b>194</b>	<b>2,244,626.06</b>	<b>102</b>	<b>180,308.17</b>

Санхүүгийн аудиттай холбоотой тоон мэдээллүүдийг харьцуулан үзэхэд 2025 онд зөрчил буурч, эерэг үзүүлэлт гарсан байна.

Сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдэж буй байгууллагуудын /ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС/ аудитын дүгнэлтээр 2023 онд 6 сум, 2024 онд 1 сум, 2025 онд 3 сум тус тус хязгаарлалттай дүгнэлт авсан байна.<sup>6</sup>

*Хүснэгт 20. Аймаг болон сумдын Засаг дарга нарын нэгдсэн санхүүгийн тайлангийн дүгнэлт*

Байгууллага	Он	Өөрчлөлтгүй дүгнэлт	Хязгаарлалттай дүгнэлт
Аймаг Засаг даргын нэгдсэн тайлан	2023	-	1
	2024	1	-
	2025	1	-
	2023	13	6
	2024	18	1

<sup>6</sup> \*Өөрчлөлтгүй-санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн үнэн зөв толилуулсан

\*Хязгаарлалттай-зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй.

19 сумын Засаг даргын нэгдсэн тайлан	2025	16	3
--------------------------------------	------	----	---

Дээрх 2 хүснэгтийг харьцуулан харахад 2025 онд аймгийн нийт санхүүгийн зөрчил буурсан ч сумын нэгдсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт авсан сумын тоо өссөн байна.

Аймгийн хэмжээний нийт санхүүгийн зөрчлөөс гадна сум тус бүрийн нэгдсэн тайлангаар илэрсэн зөрчил нь тухайн сумын санхүүгийн дотоод хяналт, сахилга хариуцлагатай холбоотой байдаг.

Хөндлөнгийн хяналт нь зөрчил илрүүлэх, хариуцлага тооцох, санхүүгийн сахилга батыг сайжруулахад эерэг нөлөө үзүүлж байна. Харин ижил төрлийн алдаа зөрчлүүд жил бүр давтагдан гарч байгаа нь төсөв захирагч нарын дотоод хяналт сул, төсөв санхүүгийн хууль, журмын мэдлэг дутмаг, аудитын шийдвэрийн хэрэгжилтийн биелэлт хангалтгүй байгаатай холбоотой байна.

**Төсөв, санхүүтэй холбоотой хууль, журмын заалтын ойлголтын зөрүүтэй байдлаас үүдэн Төрийн аудитын байгууллагаас хийж буй санхүүгийн тайлангийн аудитаар зарим зөрчлүүд нийтлэг илэрсэн байна. Үүнд:**

Хуулийн заалт	Практик ойлголт	ТАБ-ын санал
Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасан “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно”	“Үр бүтээл гарган ажилласан” гэх ойлголтыг үнэлэх шалгуур үзүүлэлт, хэмжих аргачлал тодорхойгүй байгаагаас төсвийн захирагчид өөр өөрийн тайлбар, үнэлгээнд үндэслэн мөнгөн урамшуулал олгож байгаа нь төрийн албан хаагчид олгогддог бусад мөнгөн урамшуулалтай давхардах нөхцөл үүсгэж байна.	“Үр бүтээл”-ийг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг тодорхой болгож, холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох
Төсвийн тухай хуулийг үндэслэн баталсан Сангийн сайдын 2021 оны “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 5.2-д “Тухайн шатны Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн нэгж шийдвэрийн төсөл болон холбогдох тооцоог хянаж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна”	Практикт аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахтай холбоотой захирамжийн төслийг боловсруулж, холбогдох хэлтсийн дарга нараар хянуулсны үндсэн дээр эцсийн төслийг тухайн шатны Засаг даргаар батлуулж байгаа бөгөөд Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажиллагаа хэрэгжихгүй байна.	Санхүү, төрийн сангийн нэгж шийдвэрийн төсөл болон холбогдох тооцоог хянаж, хурлаар хэлэлцүүлэх асуудлыг хуульд нийцүүлснээр Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж, зарим үйл ажиллагаанд тавих хязгаарлалтыг зөрчсөн зөрчлүүд буурна

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсөв захиран зарцуулж буй байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч, төрийн сангийн гүйлгээний хяналт хэрэгжүүлж буй төрийн сангийн мэргэжилтнүүдийн төсөв, санхүүтэй холбоотой хууль, журмын заалтын ойлголтын зөрүүтэй байдлаас үүдэн санхүүгийн тайлангийн аудитаар нийтлэг зөрчлүүд илэрч байна.

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



### ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,

Утас/Факс: (976) 7032 2073,

Цахим шуудан: uvurkhangai@ov.gov.mn

Цахим хуудас: www.uvurkhangai.mn

2026.05.29 № 3/292

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрийн сангийн тогтолцоо хууль тогтоомжийн  
нийцлийн аудитын тайлангийн төсөлд саналгүй  
болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Ц.ИДЭРСАЙХАН



6226 33 0343  
D:My Doc. A5 alban bichig /ZDTG/

## ДҮГНЭЛТ

- Холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэрүүд хууль тогтоомжтой нийцэж байна.
- Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн хувьд төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц бүрдсэн бол сумдын төрийн сангийн хувьд албан тушаалын тодорхойлолтын боловсруулалт хангалтгүйгээс тодорхойгүй байдал үүсэж чиг үүргийн давхардал үүссэн бүтэц, зохион байгуулалт оновчгүй байна.
- Төрийн сангийн цахим системийн удирдлага, зохицуулалт, мэдээллийн аюулгүй байдал, хэрэгцээ шаардлага нь холбогдох хууль тогтоомжид нийцэж, гүйлгээ болон хянах батлах ажиллагаа цахимаар хийгдэх болсон нь цаг хугацаа хэмнэж, ажлын ачаалал тодорхой хэмжээгээр буурч, цаасан баримт багассан байна.
- Сумдын санхүүгийн дэмжлэг, орон нутгийн байгууллагуудын Үндсэн үйл ажиллагааны зардал, ОНХС-ийн санхүүжилт Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт төсвийн хязгаар, орлого бүрдүүлэлтээс хамааран батлагдсан төсөв, төсвийн хуваарийн дагуу олгогдохгүй, шат шатны байгууллагуудад төрийн сангийн үйл ажиллагааны журмын мөрдөлтийг сайжруулах шаардлагатай байна.
- Төрийн сангийн төлбөр, тооцооны гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан эсэхэд зохих хяналт, баталгаажуулалт хийх үйл ажиллагааг сайжруулж, гүйлгээг хянаж буй төрийн сангийн мэргэжилтэн, төсвийг захиран зарцуулж буй удирдлага, нягтлан бодогчдын хариуцлагыг нэмэгдүүлж, чадавхжуулах шаардлагатай байна.
- Төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж буй дотоод болон хөндлөнгийн хяналтууд нь үр нөлөөгөө өгч байгаа хэдий ч өгсөн шийдвэрийн хэрэгжилт, биелэлтийг дүгнэж, үр дүнг сайжруулах шаардлагатай байна.

## САНАЛ

### Дээд газарт уламжлуулах санал:

- Сумын Засаг даргын Тамгын газрын бүтцэд “Санхүүгийн алба” гэсэн бие даасан нэгж байхгүй бөгөөд төрийн сангийн нийтлэг чиг үүргийг Сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчид болох Төсвийн ерөнхий нягтлан бодогч болон төрийн сангийн мэргэжилтэн хэрэгжүүлж байна. Иймд Засгийн газрын 2002 оны 101 дүгээр тогтоол, Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолуудад нэмэлт өөрчлөлт оруулж, сумдын төрийн сангийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлагатай байна.
- Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 208 дугаар тогтоолоор баталсан сумдын төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай.
- Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын чиг үүрэг, статистикийн ажлын зохион байгуулалт, нэмэгдэл олгох эрх зүйн зохицуулалтын уялдаа хангалтгүй байна. Статистикийн ажил албан тушаалын чиг үүрэгт орж ирснээр сумдын мэргэжилтнүүд

төрийн сангийн үндсэн үйл ажиллагааны чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

- Системүүдийн хоорондын мэдээлэл солилцох үйл явц хийгдэж байгаа ч хэрэглэгчийн туслах цонх /системд гарсан алдаа, санал гомдлыг авах, нэгтгэх/-ны хөгжүүлэлт төлөвлөгөөний дагуу явагдахгүй удаашралтай байгаа тул хурдасгах, системд орсон өөрчлөлт бүрийг тухай бүр хэрэглэгчдэд мэдэгдэх шаардлагатай байна.
- Төрийн сангийн албан хаагчдыг төрийн сангийн үйл ажиллагааны холбогдох хууль, дүрэм, журам, заавартай холбоотой мэдээллээр бүрэн хангаж, чадавхжуулах багц сургалтыг явуулах. /шинэ ажилтнуудад чиглэсэн практик мэдлэгийг давамгайл олгох/ /сургалтын системээр дамжуулан багц сургалтуудыг зохион байгуулах/
- Боловсролын байгууллага нь гүйцэтгэлээр санхүүждэг, зардлын ангилал нь Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал” журамтай нийцэхгүй байгаа тул гүйлгээ хянахад хүндрэл гарч байна.
- Цаасан маягтуудыг цахимд шилжүүлэх /төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, эрхийн хүсэлтийн маягтууд/, цахим гарын үсгээр баталгаажуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх.
- Төрийн сангийн цахим системээр хийгдсэн 2023 оны төлбөрийн гүйлгээний хяналтын хуудаст 2025-2026 оны өөр байгууллагын орлогын хуулга, тушаал шийдвэр зэрэг анхан шатны баримтууд программын алдаанаас шалтгаалж орж ирж байгаа нь нууцлал алдагдах эрсдэлийг үүсгэж байгаа тул үүн дээр анхаарах.
- Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой гарч буй цаасан баримтын архивлалтын талаар журамд нарийн тусгах.
- Нэмэлт санхүүжилтийн дансны эрх нээх ажлыг Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан ажил үүргийн хуваарьт төсвийн ерөнхий нягтлан бодогч хариуцахаар заасан байдаг ч 2025 оны 10 дугаар сараас эхлэн орон нутгийн төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн нэмэлт санхүүжилтийн дансны эрхийг нээхээр цахим системд хөгжүүлэлт хийсэн байна. Үүнийг тодорхой болгох.
- Төрийн сангийн эрхийн бүртгэлийн цахим системд баримт бичгийн тохиргоо хийх, хэрэглэгчийн эрх үүсгэх, тохируулж олгох зэрэг ажлуудыг төрийн сангийн мэргэжилтэн хэрэгжүүлж байгаа; төсөвт байгууллагын төрийн сан дахь данс нээх, хаах, өөрчлөх хүсэлтийг төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн хянахаар цахим системийн хөгжүүлэлт хийгдсэн боловч уг чиг үүрэг нь ажил үүргийн жишиг заавар болон албан тушаалын тодорхойлолтод тус тус тусгагдаагүй байгааг тодорхой болгох.

#### **Сумдын ЗДТГ-ын дарга нарт:**

- Интернэтийн хурдны асуудлыг шийдвэрлэж төрийн сангийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх.

## **ЗӨВЛӨМЖ**

### **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.ПҮРЭВДОРЖ ТАНАА:**

- Төсөв, санхүүтэй холбоотой хууль, журмын заалтын ойлголтын зөрүүтэй байдлаас үүдэн санхүүгийн тайлангийн аудитаар нийтлэг зөрчлүүд илэрч байгаа тул санхүүгийн сахилга батыг сайжруулах, эрсдэл, зөрчлийг бууруулахын тулд төсөв захиран зарцуулж буй байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарийг нэгдсэн мэдээллээр хангаж, хэлэлцүүлэг зохион байгуулах.

### **САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ИДЭРСАЙХАН ТАНАА:**

- Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5 болон Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.10-д заасны дагуу төсвийн гүйлгээнд цахим системээр хяналт тавих үйл ажиллагааг сайжруулж, төлбөрийн хүсэлтийг анхан шатны баримтын иж бүрдэл, гэрээ, нэхэмжлэх, акт, тооцоо, эдийн засгийн ангилал болон батлагдсан төсвийн зарцуулалтын эрхтэй тулган нягтлан шалгаж хэвшүүлэх, шаардлага хангаагүй болон бүрдэл дутуу гүйлгээг буцааж, хууль, журмын хэрэгжилтийг ханган ажиллах.
- Төсөв, санхүүтэй холбоотой хууль, журмын заалтын ойлголтын зөрүүтэй байдлаас үүдэн санхүүгийн тайлангийн аудитаар нийтлэг зөрчлүүд илэрч байгаа тул төрийн сангийн гүйлгээний хяналт хэрэгжүүлж буй албан хаагчдыг нэгдсэн мэдээллээр хангаж, хэлэлцүүлэг зохион байгуулах.
- Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор баталсан “ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ын 2 дугаар зүйлийн 2.6.1-д заасны дагуу журмын 23-25 дугаар маягтыг сар бүр бүрэн хөтөлж, баталгаажуулан санхүүжилтийг эрхийг олгож байх.
- Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ын дагуу захиалагчийн хяналтын зардлын эрх олгох нэмэлт дансаар дамжуулж, Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрх олгохдоо, журмын хавсралт маягтуудын дагуу хянан зарцуулах эрхийг олгож байх.
- Бүртгэлийн дансны үлдэгдлийг хагас жил тутам бүрэн баталгаажуулах, баталгааны маягтыг эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулж; төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг, огноо, баталгаажуулалтын тэмдэглэгээг бүрэн хангаж, шат шатны хяналтыг сайжруулах.
- Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн болон өглөг, авлагын сарын мэдээ тайланг цаглаварт хугацаанд гарган, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулан Төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг, огноо, баталгаажуулалтын тэмдэглэгээний бүрдлийг хангаж, нягтлан бодогч нарт заавар зөвлөгөө өгч, хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.
- Дотоод хяналтын тайлангаар өгч буй зөвлөмжийг хэрэгжилтийг хангуулах хугацааг тайланд тусгаж, зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг бүрэн авч, тайлагнаж байх.

### **СУМЫН ЗАСАГ ДАРГА, САНХҮҮГИЙН АЛБАНД:**

- Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5 болон Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.10-д заасны дагуу төсвийн гүйлгээнд цахим системээр хяналт тавих үйл ажиллагааг сайжруулж, төлбөрийн хүсэлтийг анхан шатны баримтын иж бүрдэл, гэрээ, нэхэмжлэх, акт, тооцоо, эдийн засгийн ангилал болон батлагдсан төсвийн зарцуулалтын эрхтэй тулган нягтлан шалгаж хэвшүүлэх, шаардлага хангаагүй болон бүрдэл дутуу гүйлгээг буцааж, хууль, журмын хэрэгжилтийг ханган ажиллах.

- Жил бүрийн эрсдэлийн үнэлгээний хамт Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-ын хавсралт маягт “Төрийн сангийн үйл ажиллагааны талаар харьяа төсвийн байгууллагаас авах санал асуулгын хуудас”-г бүрэн бөглүүлж, эрсдэлийг бодитой үнэлэх.
- Бүртгэлийн дансны үлдэгдлийг хагас жил тутам бүрэн баталгаажуулах, баталгааны маягтыг эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулж; төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг, огноо, баталгаажуулалтын тэмдэглэгээг бүрэн хангаж, шат шатны хяналтыг сайжруулах.
- Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн болон өглөг, авлагын сарын мэдээ тайланг цаглаварт хугацаанд гарган, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулан Төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг, огноо, баталгаажуулалтын тэмдэглэгээний бүрдлийг хангаж, нягтлан бодогч нарт заавар зөвлөгөө өгч, хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.
- Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор баталсан “ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ын 2 дугаар зүйлийн 2.6.1-д заасны дагуу журмын 23 дугаар маягт “ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДАД САНХҮҮЖИЛТИЙН ЭРХ ОЛГОХ ЖАГСААЛТ”-ыг сар бүр бүрэн хөтөлж, баталгаажуулан санхүүжилтийг эрхийг олгож байх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хуулийн хугацаанд гаргаж 2026 оны 6 дугаар сарын 29-ний дотор, биелэлтийг, нотлох баримтын хамт 2026 оны 11 дүгээр сарын 20-ны дотор ирүүлэх.

## **ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**Хавсралт 1. Түүвэрлэсэн гүйлгээ 2023-2025 он /сая.төг/**

№	Аймаг, сумын нэр	Байгууллагын тоо	Гүйлгээний тоо	Гүйлгээний мөнгөн дүн	Зөрчилгүй гүйлгээний тоо	Зөрчилгүй гүйлгээний дүн	Аудитаар илэрсэн зөрчил																
							Нийт зөрчлийн тоо	Нийт зөрчлийн мөнгөн дүн	Анхан шатны баримтын бүрдэл дугуу		Тушаал шийдвэр байхгүй		Гарын үсэг дугуу		2025-2026 оны буруу баримт хяналтын хуудаст орж ирсэн		Буруу баримт хавсаргас		Гүйлгээний утга		Эдийн засгийн ангилал зөрүүтэй		
									тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	Аймгийн СТСХ	11	102	701.5	61	517.9	41	183.6	27	141.6					8	12.5		6	29.50				
2	Арвайхээр	10	42	134.7	22	91.3	20	43.4	3	0.6					12	40.0		5	2.80				
3	Бат-Өлзий	9	92	282.9	57	209.6	35	73.3	14	45.1					14	14.6		6	13.20	1	0.4		
4	Зүүнбаян-Улаан	6	86	172.2	52	93.0	34	79.2	10	8.4	5	30.2			11	36.6		8	4.00				
5	Өлзийт	6	29	30.4	23	18.7	6	11.7	4	2.8					2	8.9							
6	Сант	6	49	111.1	37	55.1	12	55.9	4	28.1					8	27.8							
7	Төгрөг	6	66	271.4	51	252.2	15	19.2	3	2.8					2	5.5		10	10.90				
8	Уянга	10	192	565.0	87	409.4	105	155.6	73	116.3	1	0.2	3	1.61	11	12.8		15	23.20	2	1.4		
9	Хархорин	22	411	1,462.7	336	1,173.2	75	289.5	12	40.8	1	0.4			28	155.7		25	58.10	9	34.4		
10	Хужирт	9	50	158.9	14	49.4	36	109.5	8	15.7					16	78.8		12	15.10				
	<b>2023 он нийт дүн</b>	<b>95</b>	<b>1,119</b>	<b>3,890.8</b>	<b>740</b>	<b>2,869.8</b>	<b>379</b>	<b>1,021.0</b>	<b>158</b>	<b>402.2</b>	<b>7</b>	<b>30.8</b>	<b>3</b>	<b>1.6</b>	<b>112</b>	<b>393.3</b>		<b>87</b>	<b>156.90</b>	<b>12</b>	<b>36.2</b>		
1	Аймгийн СТСХ	13	211	277.4	148	233.8	63	43.7	27	20.2	2	3.1	3	1.82				29	17.80	2	0.8		
2	Арвайхээр	6	28	105.2	26	104.1	2	1.1										2	1.10		0		
3	Бат-Өлзий	9	114	1,578.6	111	1,575.5	3	3.1	2	2.5								1	0.60		0		
4	Зүүнбаян-Улаан	6	101	314.1	77	228.6	24	85.6	9	9.8	4	71.5						11	4.20		0		
5	Өлзийт	3	15	115	10	72.8	5	42.5	5	42.5											0		
6	Сант	6	51	215.3	47	210.4	4	4.8			1	3.0	1	0.17				2	1.6		0		
7	Төгрөг	6	65	298.5	46	261.7	19	36.9	2	18.7								17	18.20		0		
8	Уянга	6	179	639.8	123	490.5	56	149.3	47	127.7			1	1.00				4	9.00	4	11.5		
9	Хархорин	21	270	3,141.8	249	2,958.9	21	182.9	3	39.3	1	12.9					1	0.6	3	25.70	13	104.4	
	<b>2024 он нийт дүн</b>	<b>76</b>	<b>1,034</b>	<b>6,686.1</b>	<b>837</b>	<b>6,136.4</b>	<b>197</b>	<b>549.8</b>	<b>95</b>	<b>260.6</b>	<b>8</b>	<b>90.5</b>	<b>5</b>	<b>3.0</b>				<b>3</b>	<b>2.2</b>	<b>67</b>	<b>76.60</b>	<b>19</b>	<b>116.8</b>
1	Аймгийн СТСХ	14	218	708.9	164	563.5	54	145.4	11	66.4	2	3.1	3	1.00				38	74.87				
2	Арвайхээр	11	59	103.9	29	71.0	30	32.9	10	7.7				0.00				20	25.26				
3	Бат-Өлзий	9	267	976.2	248	911.5	19	64.7	11	20.5								1	0.32	7	43.8		
4	Зүүнбаян-Улаан	6	198	590.3	173	508.1	25	82.2	23	67.0	1	8.0								1	5.2		
5	Өлзийт	6	39	56.0	28	46.0	11	10.0	7	6.8	2	1.6	2	1.53									
6	Сант	6	142	173.4	137	137.2	5	36.1	1	23.5										4	12.6		
7	Төгрөг	6	84	220.2	67	126.4	17	93.8	15	73.3										2	20.5		
8	Уянга	10	300	1,683.4	253	1,477.3	47	206.2	44	140.1			2	13.71				1	5.88	5	46.4		
9	Хужирт	9	223	268.3	132	201.1	91	67.2	2	15.8	25	11.7		-				63	39.47	1	0.3		
	<b>2025 он нийт дүн</b>	<b>77</b>	<b>1,530</b>	<b>4,780.5</b>	<b>1,231</b>	<b>4,042.1</b>	<b>299</b>	<b>738.4</b>	<b>124</b>	<b>423.0</b>	<b>30</b>	<b>24.5</b>	<b>7</b>	<b>16.2</b>				<b>123</b>	<b>145.80</b>	<b>20</b>	<b>128.9</b>		

## ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/16

Арвайхээр сум

#### Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсэг, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалт, 2025 оны А/161 дүгээр тушаалаар баталсан “Аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Ө.Ринчинмядаг)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллан, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан), сумдын Санхүүгийн албаны дарга нарт тус тус хариуцуулсугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Аудитын менежер (П.Хорлоосүрэн), Ахлах аудитор (Ө.Ринчинмядаг) нарт даалгасугай.

5. “Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”-д хийсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор статистик мэдээний бүртгэлийн маягтын дагуу бүртгэн баталгаажуулж, 5 хоногийн дотор Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Нийцлийн аудитын ахлах аудитор (Ө.Ринчинмядаг), Аудитор, эрх зүйч (Б.Нямсэмжаан)-д тус тус үүрэг болгосугай.

6. Аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах үйл ажиллагааг ахлах аудитор (Ө.Ринчинмядаг)-т хариуцуулсугай.

7. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 30 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Р.Энхзул)-д үүрэг болгосугай.



О.БАТЖАРГАЛ

6225010000

D:\Audiitiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

**Утас:** +976 7032-3253, 70323-833, 7032-3108  
**Цахим шуудан:** [uvurkhangai@audit.gov.mn](mailto:uvurkhangai@audit.gov.mn)  
**Цахим хуудас:** [www.audit.mn](http://www.audit.mn)

**Хаяг:** Монгол улс, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон